

ILF

THE INTERNATIONAL
LEGAL FOUNDATION

ОУЭЗС

ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН САН



Шударга ёсыг үнэлэх нь

Эрүүгийн хэрэгт хууль зүйн мэргэжлийн
туслалцаа үзүүлэгчийн чанарыг
тодорхойлж, үнэлгээ өгөх нь

2016 оны 11-р сар

© 2016 Олон Улсын Эрх Зүйн Сан. Энэхүү номын зохиогчийн эрхийг хуулиар хамгаалсан тул зөвшөөрөлгүйгээр хэвлэн олшруулах, санааг өөр бүтээлд ашиглахыг хориглоно.

Нийтэлсэн:

Олон Улсын Эрх Зүйн Сан (ОУЭЗС) 111 Жон гудамж, #1040 Нью Йорк хот 10038

www.theilf.org Дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл press@theilf.org цахим хаягруу бичнэ үү.

Олон Улсын Эрх Зүйн Сан (ОУЭЗС) бол ядуу иргэдийн хууль зүйн мэргэжлийн туслалцаа авах эрхийг дэлхий дахинаа хамгаалагч байгууллага бөгөөд дайн, сөргөлдөөний дараах болон шилжилтийн үеийн улс орнууд дах ядуу, эмзэг бүлгийн сэжигтэн, яллагдагчдад чанарын өндөр төвшинд эрүүгийн хууль зүйн мэргэжлийн туслалцааны үйлчилгээ үзүүлдэг мэргэжилтнүүдээс бүрддэг.

ОУЭЗС-ийн дотооддоо баримталдаг гол үзэл баримтлал бол чанарын өндөр төвшинд эрүүгийн хэрэгт үр дүн бүхий хууль зүйн, өмгөөллийн үйлчилгээг хүргэх зорилгоор хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэгчийн чадавхыг сайжруулахыг эрмэлзэх явдал юм.

Одоогийн байдлаар ОУЭЗС нь Афганистан, Непал, Тунис ба Баруун эрэг зэрэг улсад 40,000 гаруй хүнийг өмгөөлж, хэдэн зуун хуульчдыг сургаж бэлтгэлээ. Мөн ОУЭЗС нь дэлхийн улс орнууд, хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэгч ба олон улсын байгууллагуудад тогтмол зөвлөгөө өгч, туслалцаа үзүүлж ажилладаг. Хууль зүйн мэргэжлийн туслалцааны тухай анхны олон улсын хэм хэмжээний баримт бичиг болох “Эрүүгийн хэрэгт хууль зүйн мэргэжлийн туслалцаа авах эрхтэй холбоотой НҮБ-ын баримтлах зарчим, зөвлөмж” болоод НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр and НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албаас гаргасан “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хууль зүйн мэргэжлийн туслалцаа эрт авах тухай хууль тогтоогч болон хуульч, өмгөөлөгчдөд зориулсан гарын авлага”-ыг боловсруулахад ОУЭЗС-ийн гүйцэтгэсэн үүрэг оролцоо их байв.

2014 онд, ОУЭЗС-гийн тусламжтайгаар эрүүгийн хууль зүйн мэргэжлийн туслалцааны тухай дэлхийн анхны олон улсын чуулга уулзалтыг Өмнөд Африкт зохион байгуулж байсан бол 2016 оны 11-р сард ОУЭЗС хоёр дугаар чуулга уулзалтыг Аргентин улсад хамтран зохион байгуулахаар ажиллаж байна.

ОУЭЗС-гийн зүгээс дэлхийн дахинаа хууль зүйн мэргэжлийн туслалцааг хөгжүүлэх үйлсэд энгүй ихээр тусалж дэмждэг Нээлттэй нийгэм сан болон Оак Санд гүнээ талархаж байгаага илэрхийлэхийн сацуу тэдний тусламж дэмжлэгтэйгээр энэхүү нийтлэлийг боловсруулж гүйцэтгэсэн болохыг мэдэгдэхэд таатай байна.

Шударга ёсыг үнэлэх

ХУРААНГУЙ 4

НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР 7

I-Р ХЭСЭГ

ЯАГААД ЧАНАР ЧУХАЛ ВЭ? 8

Хууль зүйн мэргэжлийн туслалцаа авах эрх гэдэг нь Чанартай хууль зүйн мэргэжлийн туслалцаа гэсэн үг 9

Чанартай хууль зүйн мэргэжлийн туслалцаа = Үйл явц + Үр дагавар 11

Чанарын баталгаа 12

II-Р ХЭСЭГ

ЧАНАР ГЭЖ ЮУ ВЭ? 14

Чанар тодорхой байдлаас эхэлнэ 15

Хууль зүйн мэргэжлийн туслалцааг бүрдүүлдэг эрхүүд 15

Үйлчлүүлэгчийн эрхээс эхлээд өмгөөлөгчийн гүйцэтгэлийн стандарт хүртэл 16

Олон улсын гүйцэтгэлийн стандартын зөвшилцлийг бий болгох 18

III-Р ХЭСЭГ

БИД ЧАНАРЫГ ХЭРХЭН ҮНЭЛЭХ ВЭ? 22

Чанарын баталгааг бий болгох 23

Яагаад үнэлэх гэж? 23

Эрүүгийн хууль зүйн мэргэжлийн туслалцааны хөтөлбөрт үнэлгээ өгөх 25

Бид юунд үнэлгээ өгөх вэ? 28

Хураангуй

Шударга шүүхээр шүүлгэх эрхийн хүрээнд гэмт хэрэгт яллагдсан, хуульч авах төлбөрийн чадваргүй хүмүүст хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэх шаардлагатай. Гэвч шүүх дээр зүгээр л нэг хуульчийг байлцуулах нь энэхүү шаардлагыг хангасан гэсэн ойлголт биш. Эдүгээ улам ихээр төрөн гарч буй олон улсын хэм хэмжээний дагуу төлбөрийн чадваргүй яллагдагчдад чанартай хууль зүйн мэргэжлийн туслалцаа авах эрхийг хангахын тулд юуны түрүүнд хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэгч сайтар бэлтгэгдсэн байж, ур чадвар, туршлага бүхий мэргэжлийн хүмүүс байхыг шаардаж байгаа ба ийнхүү тэд шударга үр дагаврыг авчрах ажээ.

Энэхүү тайлангаар эрүүгийн хууль зүйн мэргэжлийн туслалцааны үйлчилгээний чанарыг тодорхойлж, үнэлэхтэй холбоотой шилдэг туршлагын талаарх зөвшилцлийг олон улсын хэмжээнд бий болгохыг зорьсон болно. Энэ нь дараах гурван үндсэн асуудлыг хөндөнө:

- 1. Чанар бол чухал.** Чанар гэдэг бол хууль зүйн мэргэжлийн туслалцаа авах болон шударга шүүхээр шүүлгэх хүний эрхийн үндсэн бүрэлдэхүүн хэсэг юм. Хууль зүйн мэргэжлийн туслалцаа авах эрүүгийн хэргийн яллагдагчийн эрхийг чанартай хууль зүйн мэргэжлийн туслалцааг чанарын өндөр төвшинд хүргэхгүйгээр хангахад хүндрэлтэй буюу барагтаа боломжгүй.
- 2. Бид чанартай хууль зүйн мэргэжлийн туслалцааг тодорхойлох бүрэн бололцоотой.** Бид хууль зүйн мэргэжлийн туслалцааг чанартай хүргэх гэдгийг олон улсын хэм хэмжээний хүрээнд зөвшилцөлд хүрэх замаар бүрэн тодорхойлох боломжтойн зэрэгцээ хууль зүйн мэргэжлийн туслалцаа

үзүүлэгч шударга ёсыг хангаж, түүний баталгааг нэмэгдүүлж, улмаар үйлчлүүлэгчдэдээ эрх чөлөөг бүрдүүлэхэд ямар арга хэмжээг авч ажиллах тухай ойлголтыг тодорхойлох бололцоо бидэнд бий. Эдгээр хэм хэмжээг эрүүгийн хэрэгт хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэгчийн баримтлах гүйцэтгэлийн стандартад тусгах нь зүйтэй юм.

- 3. Бид чанартай хууль зүйн мэргэжлийн туслалцааг хэмжиж, үнэлэх боломжтой.** Хэмжүүр бол үнэлгээний чухал хэсэг-эрүүгийн хууль зүйн мэргэжлийн туслалцааны үйлчилгээний чанарын системчилсэн тодорхойлолтыг гаргахын тулд хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэгч өөрсдийн үйлчлүүлэгчдэдээ хууль зүйн мэргэжлийн туслалцааг чанартай хүргэх үүргээ биелүүлж байгаа эсэхийг хэмжиж, үнэлгээ өгөх шаардлага бий болдог.

Тайлангийн I-р хэсэгт хууль зүйн мэргэжлийн туслалцаанд үнэлгээ өгсөн жишээнүүдийн үндсэн дээр чанар яагаад нэн чухал болохоос гадна чанартай хууль зүйн мэргэжлийн туслалцааны жишээний тусламжтайгаар эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хэрхэн шударга явагдах боломжтой, мөн шүүхээр хэрэг нь шийдвэрлэгдсэн эмзэг бүлгийн иргэдэд ямар эерэг үр дүн бий болсныг харж болно.

Тухайлбал:

- өөрсдийн үйлчлүүлэгчтэйгээ эрт бөгөөд тогтмол уулзсанаар хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэгч үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг хангахын зэрэгцээ шударга шүүхийн ажиллагаанд итгэх итгэлийг нэмэгдүүлдэг байна.
- өөрийн үйлчлүүлэгчийг цагдан хоригдох эсэхийг хэлэлцэх шүүхийн

хуралдаанд дээр өмгөөлсөн хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэгч тухайн

• хууль зүй, өмгөөллийн үйлчилгээний бэлтгэл ажлыг бүрэн гүйцэд сайтар хангаж, хэргийн талаарх бүхий л холбогдох баримтыг судалсан хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэгч нь ял оногдуулахаас сэргийлэх эсхүл ялын хэмжээг бууруулах боломжтой. Эдгээр жишээнүүд болон хууль зүйн мэргэжлийн туслалцаа авах эрүүгийн хэргийн яллагдагчийн эрхтэй холбоотой олон улсын хэм хэмжээнээс харахад эрүүгийн хууль зүйн мэргэжлийн туслалцаа нь тодорхой үйл ажиллагааг эрхлэхээс гадна тодорхой үр дагаварт хүрэх тухай ойлголт юм. Өөрөөр хэлбэл: хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэгч хууль зүйн мэргэжлийн туслалцааны шилдэг жишигтэй нийцүүлэн өөрийн үйл ажиллагааг хийж гүйцэтгэн, улмаар шударга үр дагаврыг авчирсан тохиолдолд түүнийг чанарын өндөр төвшинд хууль зүйн мэргэжлийн туслалцааг үзүүлсэнд тооцно. Чанарын өндөр төвшинд хууль зүйн мэргэжлийн туслалцааг үйлчлүүлэгчдээ хүргэхийн тулд эрүүгийн хууль зүйн мэргэжлийн туслалцааны нийгэмлэг чанарын баталгааг хангах шаардлагатай. Үүний тулд эхлээд чанар гэдэгт юуг ойлгох тухай нарийвчлан тодорхойлж, хууль зүйн мэргэжлийн туслалцааны үйлчилгээний үйл явц ба үр дагаврыг хэмжиж, үнэлгээ өгөх аргачлалыг боловсруулбал зохино.

II-р хэсэгт шилдэг жишигт тооцогдох хууль зүйн мэргэжлийн туслалцааны үйлчилгээний төрлийг нарийн ялгаж салгах замаар чанар болон чанартай хууль зүйн мэргэжлийн туслалцааны үндсэн бүрэлдэхүүн хэсгүүдийг нарийвчлан тодорхойлсон болно.

Олон улсын нийгэмлэг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд яллагдагчдын эрхийг хамгаалж, шударга шүүхээр шүүлгэх эрхийг хангахтай холбоотой хэм хэмжээний талаарх нэгдсэн ойлголтыг бий болгохын тулд нэлээдгүй их цаг хугацаа зарцуулсан. Эдгээр хэм хэмжээгээр үндэслэлгүйгээр

үйлчлүүлэгчийг шүүхийн өмнөх шатанд эрх чөлөөтэй байх баталгааг бий болгож чадна.

баривчлагдах эсхүл шүүхийн өмнөх шатанд дур мэдэн цагдан хоригдохоос ангид байх, яллах дүгнэлттэй бие даан танилцаж, өөрийгөө өмгөөлөх, өмгөөлүүлэх боломжтой байх, буруутгаж буй гэрчээс асуулт асуух, нүүрэлдүүлж мэдүүлэг авах, нотлох баримттай танилцах болон давж заалдах зэрэг эрүүгийн хэрэгт яллагдагчдын үндсэн эрхийг баталгаажуулсан болно.

Нөгөөтээгүүр, яллагдагчдын эдлэх эл эрхүүдээр дамжуулж хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэгчийн үүрэг хариуцлагыг тодорхойлох боломжтой. Тодруулбал, яллагдагчдыг чанарын өндөр төвшинд төлөөлөхөд ямар хууль зүйн мэргэжлийн туслалцаа, үйлчилгээ үзүүлсэн байх шаардлагатай вэ гэдэг асуултын хариултыг харж болно. Эдгээр үйл ажиллагааг өмгөөллийн гүйцэтгэлийн стандартад тусгах нь зүйтэй. Гүйцэтгэлийн стандарт гэдэг нь эрүүгийн хэрэгт хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэгчийн хийх ёстой үйл ажиллагаа буюу өөрийн үйлчлүүлэгчийн өмнө хүлээсэн үүргийг нарийвчлан тогтоосон бичмэл зааварчилгаа юм. Эрүүгийн хэрэгт хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэгчдийн олон улсын нийгэмлэг хамтарч дэлхийн улс орнуудад нэгдсэн журмаар үйлчлэх гүйцэтгэлийн стандартын загварыг тогтоовол зохино. Хэдийгээр энэхүү тайлангийн хүрээнд багц стандартыг боловсруулах хэцүү ч гэсэн **II-р хэсэгт** эрүүгийн хэрэгт хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэгчийн үндсэн үүргийг тодорхойлсон, үйл ажиллагаанд баримтлах арван зарчмыг санал дэвшүүлсэн байгаа. Доор заасан арван зарчим нь чанартай эрүүгийн хууль зүйн мэргэжлийн туслалцааны тулгуур багана болно. Үүнд:

1. Эрт төлөөлөх. Хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэгч үйлчлүүлэгчийг баривчлагдах эсхүл баривчлагдсан, цагдан хоригдсон даруйд, аливаа байцаалтыг авахаас

өмнө цаг алдалгүй уулзах, өмгөөлөгчөөр томилогдсоноос хойш 24 цагийн дотор үйлчлүүлэгчтэй уулзаж ярилцана.

2. Үйлчлүүлэгч төвтэй өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх . Үйлчлүүлэгчид бүрэн гүйцэд мэдээлэл зөвлөгөөг өгч, хэрэгт холбоотой чухал шийдвэрийг гаргахад туслалцаа үзүүлнэ.

3. Шүүхийн өмнөх шатанд эрх чөлөөтэй байх эрхийг хангах. Хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэгч шүүхийн өмнөх шатанд баривчлагдах, цагдан хоригдохоос сэргийлж, таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан бол суллах арга хэмжээг аль болох цаг алдалгүйгээр авч ажиллана.

4. Хараат бус байдлаар үйл баримтыг судлан шинжих нөхцөлийг бүрдүүлэхэд оролцох . Хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэгч бие даасан хэлбэрээр үйл баримтыг судлан шинжлэх арга хэмжээг авах. Үүнд: хэргийн газар очиж танилцах, боломжит бүх гэрчүүдтэй уулзаж ярилцах г.м. хамаарна.

5. Бэлтгэл ажлыг сайтар хангах. Хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэгч уялдаа холбоо, үр бүтээл бүхий, иж бүрэн цогц хэргийн төлөвлөгөө, стратегийг боловсруулж, шүүх хуралдаан тус бүр оролцох бэлтгэл ажлыг сайтар хангах..

6. Шинжээчийн оролцоог хангах. Хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэгч мэргэжлийн шинжээчдээс зөвлөгөө авах, тэднийг хамруулах, мөн гэрчүүдийг оролцуулна.

7. Шүүхийн өмнөх шатны ажиллагаанд оролцох. Шүүхийн өмнөх шатны бүх ажиллагаанд үйлчлүүлэгчид ашигтай байж болохуйц бүхий л гомдол, хүсэлтийг цаг тухайд нь гаргах, материаллаг болон процессын эрх зүйн хэм хэмжээг ур чадвар, туршлагадаа тулгуурлан зөв ба оновчтой хэрэглэнэ.

8. Шүүхийн шатанд үйлчлүүлэгчийг хамгаалах. Хууль зүйн мэргэжлийн

туслалцаа үзүүлэгч тодорхой, оновчтой, хүчтэй үндэслэлүүдийг гаргаж, хууль болон үйл баримтуудыг зөв хэрэглэх, гэрчүүдэд зүй зохистой, оновчтой асуултыг тавина.

9. Ял оногдуулах бүх нөхцөл байдалд оролцох. Эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх, хөнгөрүүлэх, хамгийн бага эрүүгийн хариуцлагыг оногдуулах нөхцөлийг судлах, үйлчлүүлэгчийг хамгаалах, боломжтой бол эрүүгийн хариуцлага дундаас сонгох боломжийг шүүгчид бий болгож хамгийн бага ялыг оногдуулах боломжийг танилцуулна.

10. Хэргийг давж заалдах. Цаг алдахгүйгээр давж заалдах, хяналтын шатанд гомдол гаргах, үйлчлүүлэгчийн эрх, ашиг сонирхлыг зөрчсөн байж болзошгүй бүхий л асуудлыг хууль тогтоомжийн хүрээнд хөндөж танилцуулна.

Эцэст нь, тус тайлангийн **III-р хэсэгт** хууль зүйн мэргэжлийн туслалцааг хэмжиж, үнэлгээ өгөх аргачлалыг танилцуулахын зэрэгцээ эдгээр мэдээллийн тусламжтайгаар өмгөөлөгчид хэрхэн өөрсдийн нөөц бололцоог бүрдүүлж баталгаажуулан, хууль зүй, өмгөөллийн тогтолцоо, цаашлаад үйлчлүүлэгчид үзүүлэх үйлчилгээний чанарыг боловсронгуй болгох арга замуудыг тайлбарлав. III-р хэсэгт эрүүгийн хууль зүйн мэргэжлийн туслалцааны үйлчилгээний чанар ба үр дүнгийн талаарх мэдээллийг цуглуулахад ашиглаж болох үйл явц, үр дагавар болон зардал ба ашгийн гэх үнэлгээний гурван төрлүүдийг тайлбарлаж, дэлхийн зарим улс орнуудад тус үнэлгээг хэрхэн практик дээр хэрэглэсэн тухай жишээг харууллаа. Өөрсдийн үйл ажиллагаанд үнэлгээ өгөхдөө өмгөөлөгч болон хууль зүйн туслалцаа үзүүлэх мэргэжилтэн дараах шалгуурын үндсэн дээр хууль зүйн туслалцааны чанарын үзүүлэлтийг хэмжих нь зүйтэй. Үүнд:

- **Хэрэгцээ шаардлага хангасан** – хэмжигдэхүүнийг сонгохдоо үнэлгээний хэрэгцээ шаардлагыг харгалзан үзэж, түүнд нийцүүлэх;

- **Биелэгдэх боломжтой** – цуглуулахад харьцангуй хялбар хэмжигдэхүүнийг сонгох;

- **Уялдаа холбоо бүхий** – хэмжигдэхүүн болон үнэлгээний шалгуур хоорондын харилцан хамаарлыг шууд ойлгож мэдэхэд хялбар байх.

Тайлангийн төгсгөлд эрүүгийн хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэгчид 1) үйл

Нэр томъёоны тайлбар

Хууль зүйн мэргэжлийн туслалцааны үйлчилгээ гэдэгт хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэгч өөрийн үйлчлүүлэгчээ төлөөлөх явцад гүйцэтгэдэг тодорхой ажил үүрэг, даалгаврыг ойлгоно. Жишээлбэл, үйлчлүүлэгчтэй уулзаж ярилцах, түүнд зөвлөгөө өгөх, шүүхэд хүсэлт гомдол гаргах, хэргийг мөрдөн байцаах, хэргийн үйл баримтыг судлан шинжлэх, үйлчлүүлэгчийг шүүхэд өмгөөлөх зэрэг ажиллагаа хамаарна.

Хууль зүйн мэргэжлийн туслалцааны үйлчилгээг тоолох боломжтой байдаг. Өөрөөр хэлбэл, тоон үзүүлэлтийн дагуу түүний чанарыг үнэлж болно. Онолын хувьд, хууль зүйн мэргэжлийн туслалцааны үйлчилгээг зөв зүйтэй хүргэсэн бол үр дагаварт нь хүссэн үр дагавраа бий болгох юм.

Үнэлгээ гэдэгт эрүүгийн хууль зүйн мэргэжлийн туслалцааны үйлчилгээний чанар ба үнэ цэнийг тодорхой тогтоосон шалгуурын үндсэн дээр системчлэн судлан шинжлэх явдлыг ойлгоно.

Хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэгч гэдэгт хуульч, хуульчийн туслах, хууль зүйн оюутан эсхүл бусад мэргэжилтэн зэрэг эрүүгийн хэрэгт яллагдсан этгээдэд шууд хэлбэрээр хууль зүйн мэргэжлийн туслалцааны үйлчилгээ үзүүлэгч этгээд хамаарна.

Хууль зүйн мэргэжлийн туслалцааны үйлчилгээ үзүүлэгч гэдэгт хууль зүйн мэргэжлийн туслалцааны

- **Үндэслэл бүхий** – үнэлгээний шалгуурын талаар чухал мэдээллийг өгч болохуйц хэмжигдэхүүн байх; ба

ажиллагааны тодорхой зарчмын үндсэн дээр чанартай хууль зүйн мэргэжлийн туслалцааны чанарыг тодорхойлохоос эхлээд 2) тухайн үйлчилгээний үр дагавар болоод үр дүнг хэмжих хэмжүүрийг сонгож болохыг харуулсан үнэлгээний загварыг авч үзсэн болно.

үйлчилгээ үзүүлэхээр хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэгчийн хөдөлмөрийн гэрээ эсхүл контрактын үндсэн дээр ажиллуулагч байгууллага эсхүл агентлагийг ойлгоно.

Үр дагавар гэдэгт хууль зүйн мэргэжлийн туслалцааны үйлчилгээг зүй зохистой хэлбэрээр үзүүлсний үр дагаварт бодитоор гарсан өөрчлөлтийг ойлгоно. Үр дагавар нь дангаараа хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэгчийн үйл ажиллагаанаас хамаарахгүй, харин хэд хэдэн хүчин зүйлс нөлөөлж байдаг. Энэхүү тайлангийн хүрээнд үр дагаврыг хоёр ангилалд хувааж болно. **Хэргийн үр дагавар** нь хэргийн үе шатанд илэрч, түүнийг объектив буюу гаднын өгөгдлийн дагуу хэмжиж тогтоож болдог. Тухайлбал, шүүхийн өмнөх шатанд суллах, хэрэгсэхгүй болгох, ял оногдуулах болон оногдуулсан ялын хэмжээг бууруулах гэх мэт ажиллагаа хамаарна. Харин үйлчлүүлэгч болон бусад этгээдэд мэдрэгдсэн, ойлгогдсон аливаа өөрчлөлтийн үндсэн дээр **мэдрэгдсэн үр дагаврыг** хэмжиж тодорхойлдог. Үүнд, хууль зүйн төлөөлөл, өмгөөллийн үйлчилгээний талаарх үйлчлүүлэгчийн сэтгэгдэл, сэтгэл ханамж, хэргийг шударга шийдвэрлэсэн эсэх талаарх үйлчлүүлэгчийн үзэл бодол, шүүхийн тогтолцоонд итгэх олон нийтийн чиг хандлага зэргийг дурдаж болно. Мэдрэгдсэн үр дагавар болон хэргийн үр дагавар хоорондоо харилцан хамааралтай байх нь түгээмэл. Тухайлбал: хэргийг шударгаар шийдвэрлэлээ, иймд шүүхийн үйл

ажиллагаа шударга юм байна гэж үзэж буй үйлчлүүлэгч шүүхийн тэнсэх шийдвэрийг хүлээн зөвшөөрч, тэнссэн хугацаанд дахин зөрчил үйлдэхгүй байх магадлал их. Түүнчлэн, эргээ нийгэмшиж, ажил хөдөлмөр эрхэлсэн үү, эсхүл магад тухайн гэмт хэргийг давтан үйлдсэн үү гэх бусад үр дагаварт тулгуурлан эрүүгийн хэрэгт хууль зүйн мэргэжлийн туслалцаа, үйлчилгээний чанарыг тодорхойлоход чухал нөлөөтэй байж болох ч гэсэн тус тайлангийн хүрээнд тэдгээрийг багтаагаагүй болно.

Үр дүн гэдэгт хууль зүйн мэргэжлийн туслалцааны үйлчилгээний шууд, тоон тодорхойлолтод ордог бүтээгдэхүүнийг ойлгоно. Тухайлбал: “гомдол хүсэлт гаргах” нь хууль зүйн мэргэжлийн туслалцааны үйлчилгээ бол тухайн бичгээр гаргасан гомдол эсхүл хүсэлт нь тухайн үйл ажиллагааны бодит үр дүн байх юм.

Гүйцэтгэлийн стандарт гэдэгт хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэгч өөрийн үйлчлүүлэгчийн өмнө хүлээсэн үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай үйл ажиллагааг

нарийвчлан тодорхойлсон бичгэн зааварчилгааг ойлгоно.

Чанар гэдэгт хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэгч зорилтот хууль зүйн мэргэжлийн туслалцааны үйлчилгээг үзүүлж, зорьж буй үр дүнд хүрэх магадлалыг нэмэгдүүлэх хэр хэмжээг илэрхийлэхэд чиглэсэн хууль зүйн мэргэжлийн туслалцааны үйлчилгээний шинж чанарыг ойлгоно. Чанарыг хоёр аргаар хэмжиж болно: үйл явцын хувьд /зүй зохистой хууль зүйн мэргэжлийн туслалцааны үйлчилгээг хүргэх/ болон үр дагаврын хувьд /зүй зохистой үр дүнд хүрэх/. Чанарын өндөр төвшинд төлөөлөхийн тулд зорилтот бүх үйл ажиллагааг хийж гүйцэтгэх буюу зорьж буй үр дагаврыг бий болгохыг шаарддаг хууль зүйн мэргэжлийн туслалцааны чанарын хамрах хүрээг нэг, хоёр хүчин зүйлээр тодорхойлох боломжгүй өргөн хүрээний ойлголт байдаг.

Чанарын баталгаа гэдэгт хууль зүйн мэргэжлийн туслалцааны үйлчилгээ үзүүлэхдээ чанарын шаардлагыг хангах процессыг ойлгоно.

I-P ХЭСЭГ

Яагаад чанар чухал вэ?

- Яллагдагч хууль зүйн мэргэжлийн туслалцаа авах эрхтэй ба хууль зүйн мэргэжлийн туслалцаа авах эрх гэдэг нь өөрийгөө чанарын өндөр төвшинд өмгөөлүүлэх эрх юм. Чанарын өндөр төвшинд өмгөөллийн үйлчилгээ хүргэснээр эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа шударга явагдахаас гадна эмзэг бүлгийн иргэдийн хэргийг хянан шийдвэрлэсэн шийдвэр ч гэсэн шударга ёсонд нийцсэн байдаг.

- Эрүүгийн хууль зүйн мэргэжлийн туслалцааны чанар процесс ба үр дагавар гэх хоёр хэсгээс бүрдэнэ. Эрүүгийн хэрэгт хууль зүйн туслалцааг хууль зүйн мэргэжлийн туслалцааны (процесс) шилдэг практикийг хэрэглэх замаар чанартай гүйцэтгэх боломжтой ба ийнхүү хүссэн зорилтот үр дүнд (үр дагавар) хүрдэг. Чанартай төлөөллийн үр дүнд шүүхийн өмнөх шат болон ял оногдуулснаас хойш сэжигтэн, яллагдагч эрх чөлөөтэй байх тохиолдол илүү түгээмэл байдаг учраас үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж дагаад өндөр байна.

- Үйлчлүүлэгчид үзүүлэх чанартай хууль зүйн мэргэжлийн туслалцаа, төлөөллийн тоог нэмэгдүүлэхийн тулд эрүүгийн хууль зүйн мэргэжлийн туслалцааны нийгэмлэг чанарын үзүүлэлтийг нарийвчлан тогтоож, хууль зүйн мэргэжлийн туслалцааны үйлчилгээний процесс ба үр дагаврыг хэмжих, үнэлгээ өгөх аргачлалыг тогтоох замаар чанарын баталгааг хангах үүрэгтэй.

“Чанарын өндөр төвшинд өмгөөлөх гэдэгт юу багтах вэ? Бид энэ талаар цагдаагийн хэлтэст үйлчлүүлэгчдийн саналыг тодруулж асуув. Бид гадаа гудамжинд болж буй бодит хэргүүдийг ч судалсан. Бид шүүхийн өмнөх шатанд суллах талаар цугларсан төрөл бүрийн хэрэгтэй танилцсан. Бүх хүнд шударга үйлчлэх тогтолцоог бүрдүүлэхийн тулд. Бидний нөлөөллийн үйл ажиллагааны үр дүнд цагдаа, прокурорын газрууд өөрсдийн арга барилаа өөрчилж эхэлсэн. Саяхан нэг прокурор “та бүгдийн гомдол хүсэлтийг уншиж, хуулийг ойлгож байна” гэсэн!”

Ханане Фаталлах,
Хуульч, Олон Улсын Эрх Зүйн Сан – Тунис улс



ОУЭЗС-ийн Баруун эргийн хуульчид хүнд хэцүү хэрэгт өмгөөллийн стратеги хамтдаа боловсруулж байна

Хууль зүйн мэргэжлийн туслалцаа авах эрх бол чанартай хууль зүйн мэргэжлийн туслалцаа авах эрх юм.

Хуульч авах төлбөрийн чадваргүй эрүүгийн хэргийн яллагдагчдын хууль зүйн мэргэжлийн туслалцааг үнэ төлбөргүй авах эрх нь нийтээр хүлээн зөвшөөрсөн эрх зүйн зарчим бөгөөд шударга шүүхээр шүүлгэх эрхийн нэгэн чухал бүрэлдэхүүн хэсэг болдог.

Эрүүгийн хэрэгт хууль зүйн мэргэжлийн туслалцаа авах эрхийн тухай НҮБ-ын Зарчим, зөвлөмжид “хорих эсхүл цаазын ялтай гэмт хэрэгт холбогдож цагдан

хоригдсон, баривчлагдсан, яллагдсан аль ч этгээдэд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүхий л үе шатанд хууль зүйн мэргэжлийн туслалцаа авах эрхээ эдлэх нөхцөлийг хангаж ажиллах” үүргийг улс орнуудад даалгасан. Тус НҮБ-ын Зарчим, зөвлөмж болон Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 14-р зүйлийн дагуу ихэнх улс орнууд эрүүгийн хэрэгт яллагдсан ядуу, эмзэг бүлгийн иргэд

үнэгүй хууль зүйн мэргэжлийн туслалцаа авах баталгааг хангах үүрэг хүлээдэг.

Гэвч хууль зүйн мэргэжлийн туслалцаа авах, шударга шүүхээр шүүлгэх эрхийг “үйлчлүүлэгчийг шүүх дээр төлөөлөх” төдий явцуу хэлбэрээр ойлгож болохгүй. Шударга шүүхээр шүүлгэх яллагдагчдын эрхийг хангахын тулд хууль зүйн мэргэжлийн туслалцаа, төлөөллийг чанарын өндөр төвшинд үзүүлэхийг шаардана гэж олон тооны олон улсын эрх зүйн баримт бичигт тусгасан байх ба ингэхдээ өндөр боловсрол, мэдлэг, туршлага бүхий хууль зүйн туслалцаа үзүүлэгч нь шилдэг жишиг практикийг дагаж мөрдөн, шударга үр дагаврыг бий болгох талаар зохицуулжээ.

Хууль зүйн мэргэжлийн туслалцааны талаарх судалгааны үр дүнд чанар нэн чухал болохыг тогтоожээ. Өөрийн үйлчлүүлэгчийн эрх ашгийг хамгаалах бүхий л үйл ажиллагааг эрхэлж, чанартай үйлчилгээ үзүүлэхийг зорьдог хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэгч нь шударга шийдвэр гарахад нөлөөлж чаддаг байна. Түүний үйлчлүүлэгч шүүхийн өмнөх шатанд суллагдаж, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж өндөр байхаас гадна түүнийг дагаад олон нийтийн зүгээс шүүхийн тогтолцоонд итгэл нэмэгдсэн байх магадлал өндөртэй. Хийх ёстой бүхий л үйл ажиллагааг хийснээр хүссэн шийдвэрээ гаргуулна гэсэн баталгаа биш болох нь мэдээжийн хэрэг. Хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэгчээс үл хамаарах прокурорын яллах дүгнэлт, холбогдох хууль тогтоомж болон үйл баримтыг дүгнэсэн шүүгчийн итгэл үнэмшил зэрэг бусад хүчин зүйлс хэргийн эцсийн шийдвэрт нөлөөлөх нь мэдээжийн хэрэг. Гэвч олон хэрэгт хийгдсэн судалгаа, дүн шинжилгээний үр дүнд, чанартай хууль зүйн өмгөөлөл, төлөөлөл нь бодитоор давуу байдлыг үүсгэж, хэмжиж болохуйц өөрчлөлтийг бий болгодог гэдэг нь илэрхий байна. Үүнд:

• **Хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэгч үйлчлүүлэгчтэйгээ цаг алдалгүй**

эрт бас тогтмол уулзаж ярилцсан бол тухайн үйлчлүүлэгчийн шүүх, хууль зүйн тогтолцоонд хандах сэтгэл ханамж болоод итгэх итгэл өндөр байна. Хэдийгээр үйлчлүүлэгчийн хувьд хэргийн үр дагаварт гэм буруугүйг илтгэх нотлох баримтыг гаргах, түүнийг хорих ялаас чөлөөлөх өндөр ач холбогдолтой байх боловч цорын ганц чухал үр дагаварт тооцогдохгүй. Учир нь үйлчлүүлэгчийн ойлгож мэдэрсэн буюу мэдрэгдсэн үр дагавар, өөрөөр хэлбэл хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлсний дараа үйлчлүүлэгчийн үзэл бодол хэрхэн өөрчлөгдсөн байна вэ гэдэг асуудал нэн чухал юм. Эдгээр үйлчлүүлэгчийн мэдрэгдсэн үр дагаварт шүүхийн тогтолцоо шударга юм байна гэх итгэл, үйлчлүүлэгч өөрийн хэрэгтэй холбоотойгоор чухал шийдвэр гаргах оролцоо, шүүхэд итгэх олон нийтийн итгэл хамаарч болно. Судалгаанаас үзэхэд зарим мэдрэгдсэн үр дагаварт үйлчлүүлэгчтэй уулзаж харилцсан байдал нөлөөлдөг байна. Тодруулбал, үйлчлүүлэгчтэй хэр эрт, хэр тогтмол, хэрхэн уулзсан болох нь өмгөөллийн чанарыг илтгэдэг.

АНУ-ын хэд хэдэн муж улсад туршилт хийж, хууль зүйн туслалцааны чанарт үнэлгээ өгсөн ба тус төслийн хүрээнд үйлчлүүлэгчтэй эрт уулзаж хууль зүйн зөвлөгөө өгсөн бол үйлчлүүлэгчид мэдрэгдсэн үр дагаварт сайнаар нөлөөлсөн байна. “Өмгөөлөл үзүүлэх бүх үе шатанд үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж өндөр байж, үйлчлүүлэгчийн эргэлзээ буурч, шүүх хэргийг шударгаар шийдвэрлэнэ гэх итгэл найдвар нэмэгдсэн байсан” гэх дүгнэлтэд хүрсэн ажээ.

• **Хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэгч үйлчлүүлэгчээ цагдах хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах шүүх хуралдаан дээр төлөөлж, өмгөөлснөөр үйлчлүүлэгчийг шүүхийн өмнөх шатанд эрх чөлөөтэй байх баталгааг хангаж чаддаг.**

Хэргийн бүхий л үе шатанд үйлчлүүлэгчийг түргэн шуурхай төлөөлөх нь НҮБ-ын Зарчим, зөвлөмжид тусгасан үүргийн

нэг. Хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэгч анхны боломж бүрдсэн даруйд үйлчлүүлэгчийг шүүхийн өмнөх шатанд суллаж, түүнийг эрх ашгийг эрт төлөөлснөөр үйлчлүүлэгчийнхээ хэргийг шударгаар шийдвэрлэх боломжийг хангаж, шүүхийн тогтолцооны үр нөлөөг бүхэлд нь нэмэгдүүлэхэд хувь нэмрээ оруулдаг.

АНУ-ын томоохон муж улсад хийгдсэн нэгэн судалгаанд батлан даалтын шүүхийн хэлэлцүүлэгт мэргэжлийн хуульчаар өөрийгөө төлөөлүүлсэн үйлчлүүлэгч өмгөөлөгчгүй оролцсон үйлчлүүлэгчидтэй харьцуулахад аливаа таслан сэргийлэх арга хэмжээ авахгүйгээр суллагдах тохиолдол 250%-иар өндөр байсан байна. Тус судалгааны багын дүгнэснээр “хүчирхийллийн бус төрлийн гэмт хэрэгт холбогдсон яллагдагчдыг удаан хугацаагаар хорьсон тохиолдлуудыг харахад тэд бүгд шүүхийн өмнөх шатанд өмгөөлөгч аваагүй эсхүл өмгөөлөгч үйлчлүүлэгчийг цаг алдалгүй төлөөлөөгүй гэх нэг ижил учир шалтгаантай байна.” Шүүхийн өмнөх шатанд үйлчлүүлэгчийг суллах арга хэмжээ авснаар хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэгч халдашгүй, эрх чөлөөтэй байх хүний эрхийг хамгаалж, мөн хуулийн дагуу гэм бурууг нотлох хүртэл хэнийг ч цагдан хорьж, ял ногдуулж болохгүй гэх эрх зүйн зарчмыг хэрэгжүүлж байгаа явдал мөн юм. Шүүхийн өмнөх шатанд үйлчлүүлэгчийг суллах явдал бол түр хугацаанд эрх чөлөө олгож байгаагаас илүү өргөн хүрээтэй ойлголт билээ. Үйлчлүүлэгчийн хувьд илүү хөнгөрүүлсэн ял авах боломжийг нэмэгдүүлдэг бол улс орны төвшинд авч үзвэл хоригдлын тоо буурч,

Чанартай хууль зүйн мэргэжлийн туслалцаа = Процесс + Үр дагавар

Үйл баримтыг судлан шинжлэх, үйлчлүүлэгчид цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авахаас сэргийлэх зэрэг зүй зохистой арга хэмжээг авснаар чанартай хууль зүйн мэргэжлийн туслалцааны үйлчилгээ үзүүлдэг өмгөөлөгчид

татвар төлөгчдийн мөнгийг хэмнэсэн үзэгдэл байдаг.

• **Сайтар бэлтгэл хангаж, хэргийн үйл баримттай нарийвчлан танилцаж, судалдаг хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэгч хорих ялын тоо ба хэмжээг бууруулж чаддаг.**

Хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэхдээ бэлтгэлээ сайн хангаж, үйл баримтыг бүхий л талаас нь судлан шинжилдэг өмгөөлөгч сайн бэлддэггүй эсхүл үйл баримттай бүрэн гүйцэд танилцаж судалдаггүй өмгөөлөгчтэй харьцуулахад шүүх дээр илүү сайн үр дүнд хүрч, ялаас чөлөөлж эсхүл бууруулж чаддаг болох нь 2013 онд хийгдсэн нэгэн судалгаагаар батлагджээ. АНУ-д томоохонд тооцогдох Филадельфи муж улс дахь улсын өмгөөлөгчид бусад өмгөөлөгчидтэй харьцуулахад шүүхийн өмнөх шатанд үйл баримтыг судлан шинжлэх ажилд анхаарлаа бүрэн хандуулж хийх нь олонтой байсан ба “үүний үр дүнд Филадельфи дахь өмгөөлөгчдийн үйлчлүүлэгчдийн хүний амь насны эсрэг гэмт хэрэгт ял шийтгэл хүлээх нь 19 хувиар, насаар хорих ял авах нь 62 хувиар тус тус буурсан бол хорих ял эдлэх нийт хугацаа 24 хувиар бага байв.” Мөн хэдийгээр хүн ам багатай, алслагдсан ч гэсэн Техас муж улсад улсын өмгөөлөгчид үйлчлүүлэгчтэйгээ эрт уулзаж зөвлөгөө өгч байсны тусламжтайгаар хэрэгсэхгүй болсон хэргүүдийн хувь хэмжээ өндөр байсан ажээ. “Ийм гайхалтай эерэг үзүүлэлт нь үйл баримтыг сайтар судлан шинжиж байсан хууль зүйн, өмгөөллийн багынхантай шууд холбоотой” гэж судалгааны багынхан дүгнэсэн юм.

бүхий л үйл баримтыг цаг алдалгүй судалж, зорилготой үр дүнгээ бэхжүүлэх замаар өөрийн үйл ажиллагааг зүй зохистой байдлаар хийж гүйцэтгэсэн эсэхээс хамаарна. Чанартай хууль зүйн мэргэжлийн туслалцааны тухай бидний энэхүү үзэл баримтлалыг НҮБ-ын Зарчим, зөвлөмжөөс эхлээд бусад олон улсын норм, стандартад дараах байдлаар тусгасан болно:

27. Улс орнууд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүхий л үе шатанд хууль зүйн мэргэжлийн туслалцааг цаг алдалгүй хүргүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

28. Хууль зүйн мэргэжлийн туслалцаа гэдэгт баривчлагдсан, цагдан хоригдсон этгээдэд хууль зүйн туслалцааг аливаа саад тотгоргүйгээр хүргэх, мэдээлэл харилцааны нууцлалыг хадгалах, хэргийн материалтай танилцах болон өмгөөллийн үйлчилгээ үзүүлэхэд бэлтгэх хүрэлцэхүйц цаг хугацаа, нөөц бололцоотой байх зэрэг хамаарна....

37. Улс орнууд бүх хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэгчид /өмгөөлөгчид/ ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай зохих боловсрол, бэлтгэл, ур чадвар болон туршлагыг бий болгоход чиглэсэн тогтолцоог бүрдүүлж ажиллана....

Эдгээр зарчмыг олон улсын, бүс нутгийн болон үндэсний хэмжээнд хэрэгжүүлэхээр хууль тогтоомжид тусгаж, улмаар яллагдагч бүр хамгийн багадаа дараах шаардлагыг хангасан өмгөөлөгчөөс хууль зүйн мэргэжлийн туслалцаа авах эрхийг баталгаажуулсан болно:

- Зохих бэлтгэл, туршлагатай байх;
- Материаллаг ба процессын хууль тогтоомжийн талаар нарийн мэдлэгтэй байх,
- Бүхий л шаардлагатай бэлтгэл ажлыг хийдэг байх;
- Яллагдагчийн нууцлалыг чанд хадгалж, харилцдаг байх; болон

• Хэргийн үйл баримттай нягт намбай танилцаж, зохих судалгааг хийж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүхий л үе шатанд хүчин чармайлт гаргаж, яллагдагчийн эрхийг хамгаалах.

Тус хэм хэмжээнүүдийн дагуу хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэгчдийг яллагдагчдад зүй зохистой хууль зүйн мэргэжлийн туслалцааг зөв цагт нь үзүүлж төлөөлөх, зохих мэдлэг, ур чадвар, туршлага бүхий хуульчид байхыг шаарддаг. Уг тайлангийн II-р хэсэгт чанартай төлөөлөл гэдэгт ямар үйл ажиллагааг ойлгох тухай олон улсын төвшинд тогтсон нэгдмэл ойлголтын талаар тайлбарлав.

Гэвч процесс нь чанар гэх ойлголтын ердөө нэг л бүрэлдэхүүн хэсэг болдог. Чанарын нөгөө бүрэлдэхүүн хэсэг бол үр дагавар юм. Үүнийг ойлгоход НҮБ-ын Зарчим, зөвлөмж ахиад гол эх сурвалж болох ба түүнд чанартай хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлснээр ямар үр дагавар бий болсон байх ёстойг тусгасан болно. “Шударга шүүхээр шүүлгэх эрх”, “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шударга ёс тогтоож, олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэх”-ийн зэрэгцээ чанартай эрүүгийн хууль зүйн мэргэжлийн туслалцаа нь дараах үр дүнг бий болгосон байна:

“Сэжигтний цагдаагийн хэлтэс, цагдан хорих байранд өнгөрөөх цагийг богиносгохын зэрэгцээ хоригдлын тоог бууруулж, хэргийг үнэн зөв тогтоолгүйгээр ял оногдуулах, шүүх болон хорих газрын ачааллыг бууруулах, дахин гэмт хэрэг үйлдэх эсхүл хохирогч болох эрсдэлийг бууруулах. Түүнчлэн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь хохирогч, гэрчийн эрхийг хамгаалах боломжтой. Хууль зүйн мэргэжлийн туслалцаагаар дамжуулж, хууль тогтоомжийн талаарх ойлголт, мэдлэгийг түгээн дэлгэрүүлж, улмаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нөхцөлийг бүрдүүлж болдог.”

Хууль зүйн мэргэжлийн туслалцааг зөв зүйтэй үзүүлж хүргэснээр дан ганц яллагдагч төдийгүй нийт хууль, шүүхийн засаглалд эерэг үр дагавар, нөлөөллийг бий болгодог. Мөн шударга шүүхээр шүүлгэх,

амьд явах, халдашгүй, эрх чөлөөтэй байх яллагдагч тус бүрийн хүний эрх, үндсэн эрхийг хамгаалах бөгөөд шүүх засаглал шударга байдагт итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлнэ.

“ Би өмнө өөрсдийн үйлчлүүлэгчтэйгээ ярилцаж зөвлөлдөхгүйгээр түүнийг гэмт хэрэгт үйлдсэн гэм бурууг хүлээлгэдэг хуульчидтай таарч байлаа. Одоо бид ингэж ажиллахаа больсон. Бид хэргийн газар дээр очиж, гэрчтэй уулзаж, зураг авч, баримт цуглуулж байгаа. Бидний үйлчлүүлэгчид очих үр дүн илүү сайн болж, тэд бидэнд илүү ихээр итгэдэг болсон. Бидэнд болон шүүхийн системд итгэх үйлчлүүлэгчдийн итгэл нэмэгдсэн. Бидний хувьд гүйцэтгэлийн стандарт нь үйлчлүүлэгчдээ төдийгүй шүүх засаглалд сайн үр дүнг авчрах арга хэрэгсэл юм.

Гаданфар Каманжи,

Баруун эрэг дэх Олон Улсын Эрх Зүйн Сангийн Хуулийн хэлтсийн захирал

Чанарын баталгаа

Чанарын баталгаа гэдэгт хууль зүйн мэргэжлийн туслалцааны үйлчилгээ чанарын шаардлага хангах процессыг ойлгоно. Чанарын баталгаа нэн чухал болохыг олон улсын эрх зүйн баримт бичигт тусгасан. НҮБ-ын зарчим, зөвлөмжийн 16 дугаар зөвлөмжид улс орнуудын Засгийн газарт “хууль зүйн мэргэжлийн туслалцааны чанарын стандартыг тогтоох”, “нэн ялангуяа үнэ төлбөргүй үзүүлж байгаа хууль зүйн мэргэжлийн туслалцааны үйлчилгээний чанарт мониторинг хийх, үнэлгээ өгөх тогтолцоог бүрдүүлэх”, мөн “ хүртээмж, чанар ба үр дагаврыг нэмэгдүүлэхэд бүх хууль зүйн мэргэжлийн туслалцааны

үйлчилгээ үзүүлэгчидтэй хамтарч ажиллах...” үүрэг ногдуулсан.

Тус тайлангийн II-р хэсэгт хууль зүйн мэргэжлийн туслалцааны стандарт боловсруулах аргачлалыг заасан болно. Хууль зүйн мэргэжлийн туслалцааны үйлчилгээний хүрээнд хийгдэх бүх үйл ажиллагаа хоорондоо уялдаж, чанартай байдаг. Үүний дараагаар III-р хэсэгт хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэх үйлчилгээний чанарт хэрхэн үнэлгээ өгч, чанартай өмгөөлөл, төлөөллийн үйл ажиллагааг хийж гүйцэтгэхэд шаардлагатай хууль зүйн мэргэжлийн туслалцаанд дүн шинжилгээ хийх стратеги, аргачлалыг авч үзсэн болно.

Хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэгчийг болон хууль зүйн мэргэжлийн туслалцааны тогтолцоог чанаржуулах

Бид энэ хэсэгт “хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэгч” гэдгийг эрүүгийн хууль зүйн мэргэжлийн

туслалцааны үйлчилгээ үзүүлэгч хуульч, хуульчийн туслах болон бусад хуулийн мэргэжилтнүүдийг хамруулан хэрэглэж

байна. Эдгээр хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэгчид нь тус тусдаа ажиллахаас илүүтэйгээр томоохон хууль зүйн мэргэжлийн туслалцааны тогтолцоо буюу хууль зүйн мэргэжлийн туслалцааны үйлчилгээ үзүүлэгчдийн сүлжээнд багтдаг. Бүх төлбөрийн чадваргүй эрүүгийн хэргийн яллагдагчдыг хууль зүйн туслалцаа авах боломжоор хангах зорилгоор энэхүү тогтолцоог төр засгийн зүгээс зохицуулж, санхүүжүүлэх үүрэгтэй. Хэдийгээр хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэгчид тус бүрчлэн чанарыг эрхэмлэн ажиллах нь ихэд чухал ч гэсэн хууль зүйн мэргэжлийн туслалцааны тогтолцоонд эл үйл ажиллагааны чанарыг тодорхойлсон зохицуулалт байхгүй бол бодит практик болж хэвшихэд хүндрэлтэй.

Үүнтэй холбоотойгоор хэдэн жишээ дурдъя:

- Хуульчийн туслах ажлын өдрийн хуваарьдаа өглөө бүр цагдан хоригдсон этгээдтэй түргэн шуурхай уулзах цагийг хуваарилж, шилдэг практик, стандартыг биелүүлэхээр зорин ажиллах гэтэл хариуцсан хуульч нь өөрийн туслахдаа уулзах шаардлагатай баривчлагдсан, цагдан хоригдсон этгээдийн нэрсийн жагсаалтыг гаргаж өгөхгүй, ажлыг удаашруулж, улмаар урмыг хугалах.
- Хуульч оюуны хөгжлийн бэрхшээлтэй үйлчлүүлэгчид сэтгэцийн эмгэг судлалын шинжээчийн дүгнэлт гаргуулах зэрэг шаардлагатай, зүй зохистой арга хэмжээг авахыг хүссэн ч төр засгаас шинжээчийн зардлыг хариуцахаас татгалзах.
- Ёс зүй, ур чадвар бүхий захирлаар удирдуулсан бүхэл бүтэн том хуулийн фирм нэг яллагдагчийн эрхийг хамгаалж, өмгөөлөхөөр хүчин чармайлт гаргаж байхад төр засгаас улс төрийн хараат бус байдлыг хангахгүйгээр, чанартай хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэх улсын өмгөөллийн ажиллагаанд саад учруулах.

Хязгаарлагдмал хамрах хүрээ ба зайн улмаас тус тайлан зөвхөн хууль зүйн мэргэжлийн туслалцааны үйлчилгээний чанарыг тодорхойлох, үнэлгээ өгөх асуудлыг авч үзсэн болно. Ирээдүйд бид хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэх тогтолцоонд чанарын асуудлыг зохицуулж, баталгаажуулах нь ямар чухал үр нөлөө, өндөр ач холбогдолтой болохыг илтгэсэн тайланг боловсруулахаар зорьж ажиллана.

Чанартай хууль зүйн мэргэжлийн туслалцааг бүрдүүлэхэд авах арга хэмжээний талаар дэлгэрэнгүй судлахыг хүсвэл:

- Америкийн Хуульчдын Холбооноос гаргасан “Улсын хууль зүй, өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх тогтолцоонд баримтлах арван зарчим” (2002 он) – эрүүгийн хууль зүйн мэргэжлийн туслалцааны тогтолцоог чанаржуулахад тавигдах үндсэн шаардлагын тус жагсаалтад улс төрөөс хараат бус байдлыг хангах, улсын өмгөөлөгч ба хувь өмгөөлөгчдийн холбоог аль алиных нь оролцоог бүрдүүлэх, өмгөөлөгчийг цаг алдалгүй томилох, үйлчлүүлэгчийн нууцлалыг чанд хадгалах, ажлын ачааллыг оновчтой хуваарилах, өмгөөлөгчдийг чадавхжуулах, үйлчлүүлэгчийг тууштай өмгөөлөх, улсын ялагч буюу прокурор ба улсын өмгөөлөгчдийн нөөц бололцоог тэнцвэртэй байлгах, тогтмол сургаж дадлагажуулах, хяналт, удирдлагаар хангах болон чанарын хяналт шалгалт хийх шалгуурууд багтана.
- Үндэсний хууль зүйн мэргэжлийн туслалцаа ба өмгөөлөгчдийн холбооноос гаргасан “Олон улсын хууль зүйн мэргэжлийн туслалцаа ба өмгөөлөгчдийн тогтолцоог хөгжүүлэх гарын авлага (2010 он) – эрүүгийн хууль зүйн мэргэжлийн туслалцааны тогтолцоог боловсронгуй болгоход чиглэсэн зааварчилгаа.
- НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба (UNODC)-с гаргасан “Эрүүгийн хэрэгт үзүүлэх хууль зүйн мэргэжлийн

туслалцааны тухай загвар хууль” (2016 он) – Эрүүгийн хэргийн хууль зүйн мэргэжлийн туслалцааны тогтолцоог чанарын өндөр төвшинд хүргэхэд тавигдах үндсэн шаардлагыг тусгаж зохицуулсан жишиг

хууль. Үүнд тухайлбал, хараат бус байдал, хувийн ба улсын өмгөөлөгчдийн эрх тэгш байдал, өмгөөлөгч эрт авах эрх зэрэг хамаарна.

II-Р ХЭСЭГ

Чанар гэж юу вэ?

- Хууль зүйн үйл ажиллагааны талаарх олон улсын хэм хэмжээг гүйцэтгэлийн стандартад дэлгэрэнгүй тусгах боломжтой – хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэгч өөрийн үйлчлүүлэгчийн өмнө хүлээсэн үүрэг хариуцлагыг зүй зохистой хийж гүйцэтгэхэд шаардлагатай хууль зүйн мэргэжлийн туслалцааны үйлчилгээг нарийвчлан тодорхойлсон бичгэн зааварчилгаа.
- Хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэгч эрүүгийн хэрэгт үзүүлж буй өөрийн үйлчилгээний чанарыг үнэлж, тогтмол сайжруулахад гүйцэтгэлийн стандартыг ашиглаж болно.
- Эрүүгийн хэрэгт хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэгчдийн олон улсын нийгэмлэг дэлхийн улс орнуудад нийтээр хүлээн зөвшөөрч, хэрэглэж болох гүйцэтгэлийн стандартын жишиг загварыг тодорхойлохоор хамтарч ажиллах. Ингэхдээ гүйцэтгэлийн стандартыг чанарын баталгааг хангах суурь хэмжүүр ба үнэлгээ болгож ашиглана.

Чанар тодорхой байдлаас эхэлнэ

Оновчтой хууль зүйн мэргэжлийн туслалцааны үйлчилгээг зөв хэлбэрээр олгох нь хууль зүйн мэргэжлийн туслалцаа, төлөөллийн чанарыг тодорхойлох нэгэн чухал бүрэлдэхүүн хэсэг байдаг тул бид юуны өмнө хууль зүйн мэргэжлийн туслалцаа төлөөллийн чанарыг анхнаасаа нарийвчлан тодорхойлох нь зүйтэй. Учир нь аливаа тодорхой буюу бодит зүйл дээр л чанарын асуудлыг бид авч үзэх боломжтой юм. Тодорхойлж эс чадваас бид төлөвлөж, хэмжиж эсхүл үнэлгээ өгөх боломжгүй байдалд хүрнэ.

Хууль зүйн мэргэжлийн туслалцаанд хамаарах эрхүүд

Олон улсын хэм хэмжээгээр яллагдсан бүх этгээдийн эдлэх эрхийг баталгаажуулсан бөгөөд хууль зүйн мэргэжлийн туслалцаа бол хууль зүйн туслалцаа авах төлбөрийн чадваргүй яллагдагчдын эрхийг хэрэгжүүлж, хамгаалах механизм болдог.

Харин олон улсын нийгэмлэг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь яллагдагчдын эрхийг хамгаалж, шударга ёсыг тогтоохтой холбоотой хэм хэмжээг нэгдсэн хэлбэрээр нэгэнтээ тогтоосон нь бидэнд ихэд аз завшаантай үйл явдал билээ. Өөрийн үйлчлүүлэгчийн өмнө хүлээсэн ажил үүргийг чанартай хийж гүйцэтгэхийг зорьж буй хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэгч эдгээр хэм хэмжээг гүйцэтгэлийн стандартаа болгож хэвшүүлбэл зохино.

НҮБ-ын Зарчим, зөвлөмжид хууль зүйн мэргэжлийн туслалцааг “шударга шүүхээр шүүлгэх эрх болон бусад эрхийг эдлэх үндэс, эл эрхүүдийг хэрэгжүүлэх урьдчилсан нөхцөл болдог төдийгүй эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа шударга явагддаг гэх олон нийтийн итгэлийг

бэхжүүлж хамгаалах чухал хөшүүрэг” хэмээн тодорхойлж, тайлбарласан. Хэрэв яллагдагчдын эрхийг хамгаалах нь хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэгчийн үндсэн үүргийн нэг бол эдгээр эрхтэй холбоотойгоор хууль зүйн туслалцаа үзүүлэгчийн зайлшгүй гүйцэтгэвэл зохих үүргийг тодорхойлох хэрэгцээ болон боломж бүрэн бий.

Хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэгчийн хүлээх үүрэг болон шударга шүүхээр шүүлгэх зэрэг эрхийг хангахад чиглэсэн чанартай өмгөөлөл, хууль зүйн мэргэжлийн туслалцааны хоорондын харилцан хамаарлыг нэг мөр ойлгохын тулд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тогтолцооны шударга ёстой холбоотой хэд хэдэн хэм хэмжээг багтаасан жагсаалтыг боловсруулна.

Олон улсын нийгэмлэг өргөн хүрээтэйгээр олон тохиолдолд нэгдсэн байдлаар хэрэглэж болохуйц дараах эдгээр хэм хэмжээг тогтоосон болно.

- Үндэслэлгүйгээр дур мэдэн баривчлагдах болон шүүхийн өмнөх шатанд цагдан хоригдохоос ангид байх эрх.
- Өөрийн гэм бурууг хүлээхгүй байх эрх.
- Хэргээ түргэн шуурхай шийдвэрлүүлэх эрх .
- Ялласан үйл баримтыг хараат бусаар судлан шинжлэх эрх.
- Өөрийгөө өмгөөлөх, өмгөөлүүлэх эрхийг бүрэн хэрэгжүүлэхэд шаардагдах бэлтгэл ажлыг хийх бүрэн бололцоотой байх эрх.
- Зайлшгүй мэдүүлэг өгөх гэрчийг оролцуулах эрх.
- Яллах талын гэрчээс асуулт асууж, нүүрэлдүүлж мэдүүлэг авах эрх.
- Давж заалдах эрх.

Одоогийн нарийн ээдрээтэй шүүхийн тогтолцоог үзвэл тус нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээг мэргэжлийн хуульч, өмгөөлөгчдөөс туслалцаа авалгүйгээр хэрэгжүүлэхэд хэцүү. Яллагдагчийг яллах нь прокурорын ажилд хамаарах учраас яллагдагчийн эрхийг хамгаалах нь ховор. “Эрүүгийн хэргийн өмгөөлөгчийг оролцуулахгүйгээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг процесс ба үр дагаврын хувьд шударга явуулахад хууль сахиулагчид, прокурорууд бүхэлдээ хөндлөнгийн хараат бус байдал болон тэгш байдлыг хадгалж, шүүхийн байгууллагыг идэвх санаачилгатай байж, аливаа үйл баримтад “сохроор итгэхгүй” байхыг шаарддаг. Шүүхийн практик ба судалгааг энэ барагтаа хэрэгжих боломжгүй байдаг байна...”

Түүнчлэн гудамжинд явж байгаад гэнэт баривчлагдаад цагдан хоригдсон, хууль зүйн мэдлэггүй хүн хорих газрын торны цаанаас эрхээ хамгаалахын тулд хэргийн бүх үйл баримтыг судлах боломж барагтаа үгүй бөгөөд шүүхийн өмнөх шатанд суллагдахад эсхүл шүүхийн өмнөх шатанд цагдан хорихоос авах өөр ямар арга хэмжээг хэрэглэх материаллаг ба процессын хуулиудын зүйл заалтыг ойлгож хэрэглэх бололцоогүй билээ. Шүүхийн шийтгэх тогтоол гарах хүртэл хүнийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохыг хориглосон хүний үндсэн эрхийг ийнхүү дур мэдэн, хуулиас гадуур цагдан хоригдсон хүний эрхийг зөрчсөний улмаас учирсан аливаа хохирлыг барагдуулж, эрхийг сэргээх тогтолцоо дутмаг байна.

Үүнтэй харьцуулахад, эрүүгийн хэрэгт хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэгч үйлчлүүлэгчтэй цаг алдалгүй ганцаарчлан уулзаж, түүнд өөрийн эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, гэм буруугаа хүлээхгүй байх эрхийг танилцуулж тайлбарлах гэх мэт арга хэмжээг авч ажилладаг. Тэрээр үйлчлүүлэгчийг суллах хүсэлт гаргаж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дараагийн хуралдааны бэлтгэл ажлыг хангахын тулд хэргийн материалыг

судлан шинжлэх ажиллагааг нэн даруй эхлүүлдэг. Өөрөөр хэлбэл, чанартай хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэгч

Үйлчлүүлэгчийн эрх ба хууль зүйн мэргэжлийн туслалцааны гүйцэтгэлийн стандарт

Дээрх жишээнээс харахад хүний эрхийн баталгааг хангахад эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хууль зүйн мэргэжлийн туслалцаа дангаараа хангалтгүй болно.

Олон улсын хэм хэмжээгээр бүх яллагдагчдад үндэслэлгүйгээр дур мэдэн цагдан хоригдохоос ангид байх болон Шүүхийн шийтгэх тогтоол гарах хүртэл хүнийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй байх эрхийг баталгаажуулж тусгасан байна. Бараг бүх улс орнуудад шүүхийн өмнөх шатанд яллагдагчийг сулласнаар эл эрхүүдийг хангаж хамгаалсанд тооцдог. Хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэгч процесс болон үр дагаврын хувьд хууль зүйн мэргэжлийн туслалцааг чанартай хүргэсэн эсэхийг тогтооход бид хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэгч шүүх хуралдаанд үйлчлүүлэгчийг төлөөлж оролцох, түүнд бэлтгэхэд шаардлагатай ажил үүргийг нарийн тодорхойлох хэрэгтэй.

Эс тэгвээс бидний үнэлгээ зөвхөн нийт шүүхийн системийн шударга байдлаар хязгаарлагдаж, харин тухайн өргөн хүрээний тогтолцоонд ажиллаж буй өмгөөлөгчийн буюу хувь хүний үзүүлсэн үйлчилгээний чанарт үнэлгээ өгөх бололцоогүй болно. Тодруулбал, шүүхийн шийтгэх тогтоол гарах хүртэл гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцогдохгүй байх хүний эрхийг тухайн өмгөөлөгч чанартай хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлснээр шууд хангагдах боломжгүй. Үүнийг хорт хавдрыг зөв оношлоход бүхий л арга хэмжээ авсан ч өвчтөн нь эдгэрээгүй эмчийн ажилтай харьцуулж болох юм. Хэрэв өвчтөн тодорхой хэмжээгээр эдгэрвэл бид эмчийг өвчтөнийхөө

яллагдагчийн үндсэн эрхийг хамгаалахад чиглэсэн хууль зүйн мэргэжлийн туслалцааны цогц үйлчилгээг үзүүлж ажиллана.

эрүүл явах эрхийг хангасан гэж таамаг дэвшүүлэхээс биш бид өвчтөнийг эдгэрэхэд чухам ямар хүчин зүйлс нөлөөлснийг бүрэн хэлэх боломжгүй. Гэтэл аль болох бүх хүчин зүйлсийг харгалзаж үзэх нь чухал билээ.

Иймд гүйцэтгэлийн стандарт эл асуудлын шийдэл юм. Гүйцэтгэлийн стандарт бол хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэгч өөрийн үйлчлүүлэгчийн өмнө хүлээсэн үүргийг гүйцэтгэхэд авах шаардлагатай арга хэмжээг дэлгэрэнгүй тусгасан баримт бичиг. НҮБ-ын Зарчим, зөвлөмжид “улс орнууд хууль зүйн мэргэжлийн туслалцаанд тавигдах чанарын стандартыг тогтоох арга хэмжээг авч ажиллана...” гэж тусгасан бөгөөд эдүгээ маш олон улсад үйлчлүүлэгчийн эрхийг хангаж хамгаалахад хууль зүйн туслалцаа үзүүлэгч, өмгөөлөгчийн хэрэгжүүлэх тодорхой ажил үүргийг тодорхойлж, хэмжиж улмаар үнэлгээ өгөхөд ашиглах стандартыг баталсан байна.

Маш сайн боловсруулсан стандарт эргээд хэмжиж, таамаглах боломжтой үр дүнг бий болгодог. Маш сайн боловсруулсан стандарт зорилгодоо нийцсэн, бодитой байх шаардлагатай. Ийм стандарт нь тодорхой бас зааварчилсан шинжтэй байх тул хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэгчийн сургалт, бэлтгэл ажил, үйлчлүүлэгчид үзүүлэх хууль зүйн зөвлөгөө ба зааварчилгаанд ашиглахад нэн тохиромжтой баримт бичиг болдог. Стандарт нь хууль зүйн мэргэжлийн туслалцааны үйлчилгээний процессыг стандартчилах зориулалттай гэдгийг түүний нэршлээс тодорхойлж болох ба нэг гишүүн улсын хууль зүй, шүүхийн яам “чанарыг нэгтгэх гол хэрэгсэл...Улс, үндэсний хэмжээнд стандартыг нэгдсэн журмаар

хэрэгжүүлэх явдал бол тухайн хэрэг гарч, ялласан нутаг дэвсгэр гэх ганцхан хүчин зүйлийн улмаас өмгөөлөл, хууль зүйн туслалцааны чанар, хүний эрхийг хэрэгжилт харилцан адилгүй байж, улмаар хууль зүйн үндэслэл огт байхгүй байхад, дур мэдэн хүний эрхийг зөрчих явдлыг хязгаарлах чухал хөшүүрэг” гэж стандартыг тодорхойлсон байна.

Эцэст нь, стандарт захирсан шинжтэй байна. Нэг талаараа стандартыг хэрэглэх тухайн улс орны хууль тогтоомж, дүрэм журамтай нийцүүлж гаргах ба нөгөөтээгүүр стандарт олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн

хэм хэмжээтэй нийцсэн байх ёстой. Дэлхийн улс орнуудын боловсруулж баталсан хууль зүйн мэргэжлийн туслалцааны гүйцэтгэлийн стандартыг харьцуулж үзэхэд хоорондоо ижил төсөөтэй зүйлс их бий.

2-р дүрсэд төрөл бүрийн гүйцэтгэлийн стандартууд ерөнхийдөө бүгд хууль зүй, өмгөөллийн үйлчилгээний шүүхийн өмнөх шатанд үйлчлүүлэгчийг суллах гэх үүргийг нэгдсэн журмаар тогтоосон байна.

1-р дүрс Гүйцэтгэлийн стандарт ба ёс зүйн дүрэм		
Зарим улс орнууд гүйцэтгэлийн стандартын оронд ёс зүйн журмыг эсхүл түүнтэй давхцуулж баталж хэрэгжүүлдэг. Гэсэн хэдий ч энэ хоёрын ялгаа заагийг тогтоох нь зүйтэй. Ёс зүйн дүрэм гэдэг бол гүйцэтгэлийн стандартын багц нийлбэрийн нэг хэсэг байх ба стандартыг орлох баримт бичиг биш юм.		
	Гүйцэтгэлийн стандарт	Ёс зүйн дүрэм
Зорилтот бүлэг	Хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэгчид шууд хамаарах ба гагцхүү тэдгээрээр хязгаарлагдана.	Бүх хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэгч эсхүл бүх хуульчдад ерөнхийдөө хамаарч болно.
Загварын төвшин	Ихэнхдээ тусгай зөвшөөрөл бүхий үйл ажиллагааг нарийвчлан тодорхойлж, олон улсад нэгдсэн байдлаар дагаж мөрдөхийг сурталчилдаг.	Голдуу ёс зүйн зарчмыг өргөн хүрээтэйгээр хамарч, хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааг хянуур, хариуцлагатай хэлбэрээр хийж гүйцэтгэхийг зааварчилсан. Хуульчдын өдөр тутмын ажил үүрэг гэхээс илүү ёс зүйн үйл ажиллагааг чухалчилдаг.

Улс орны онцлог	Гүйцэтгэлийн стандарт маш нарийн, дэлгэрэнгүй зааварчилгаанаас бүрддэг учир хэрэглэх тухайн улсынхаа хууль тогтоомж, дүрэм журам ба зан заншлын хэм хэмжээнд нийцсэн байх ёстой.	Маш олон улсад ёс зүйн зарчмыг ерөнхийдөө ижил хэлбэрээр ойлгож тайлбарладаг болохоор ёс зүйн дүрмийг тухайн улс орон тус бүрд нийцүүлэн боловсруулах шаардлагагүй.
Үнэлгээ өгөх чадвар	Тус стандартад тодорхой, хэмжиж болохуйц үйл ажиллагааг тусгасан байх тул тоон үзүүлэлтэд суурилсан процессын үнэлгээ гэх мэтчилэн төрөл бүрийн үнэлгээнд ашиглагддаг.	Тодорхой үйл ажиллагааг тусгаж заадаггүй болохоор ёс зүйн дүрмийг ихэнхдээ хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа, хариуцлагатай байдалд өгөх мэргэжил нэгт эсхүл шинжээчийн дүгнэлт зэрэг чанарт суурилсан үнэлгээнд ашиглагдаараа хязгаарлагдана.



ОУЭЗС-ийн Гүйцэтгэх захирал Женнифер Смит (голд) Эрүүгийн хэрэгт хууль зүйн мэргэжлийн туслалцаа авах эрхийн тухай анхдугаар Олон улсын чуулга уулзалтад оролцогчидтой уулзаж ярилцаж байна. Тус чуулга уулзалтад 70 орчим улсаас 250 гаруй хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэгч болон мэргэжилтнүүд хүрэлцэн ирж, тулгамдсан асуудал болоод сайн жишгийн талаар санал солилцсон юм.

Олон улсын гүйцэтгэлийн стандартын талаарх олон улсын нэгдмэл байр суурь

Зарим улс орнуудын баталж хэрэгжүүлж буй гүйцэтгэлийн стандарт болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шударга байдлыг тодорхойлох нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээний хоорондын ижил төсөөтэй байдлаас үзэхэд дэлхий улс орнуудын хуульч өмгөөлөгчдөд хамааралтай гүйцэтгэлийн стандартын загварыг боловсруулах замаар чанартай хууль зүйн мэргэжлийн туслалцааг хөхүүлэн дэмжих бүрэн бололцоотой.

Уг тайланд стандарт бүрийг дэлгэрэнгүй, цогц байдлаар нэг бүрчлэн танилцуулж тайлбарлаж хэвлэхэд маш их зай шаардах учраас эрүүгийн хэргийн хууль зүйн мэргэжлийн туслалцааны багц стандартыг Олон улсын эрх зүйн сангийн <http://theilf.org/> веб хуудаснаас үзэж болно.

Энэхүү тайланд бид дэлгэрэнгүй тайлбар бүхий 10 үйл ажиллагааны зарчимд суурилсан стандартыг тоймлон хүргэж байна. Тус стандартад эрүүгийн хэрэгт хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэгчийн үндсэн үүрэг буюу чанартай эрүүгийн хууль зүйн мэргэжлийн туслалцааны процессыг жагсааж оруулсан болно. 3-р дүрсэд эдгээр зарчмууд хэрхэн олон улсад нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн эрхүүдийг тусгасныг илэрхийлэв.

2-р дүрс

Улс орнуудын гүйцэтгэлийн стандартын харьцуулалт

Эх үүсвэр	Хууль зүйн мэргэжлийн туслалцааг шинэчлэгчдийн сүлжээнээс боловсруулж баталсан “Эрүүгийн хэрэгт хууль зүй, өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааны стандарт” (Украин, Молдав, Гүрж улсын үндэсний стандартад суурилсан үйл ажиллагааны загвар стандарт)	Үндэсний хууль зүйн мэргэжлийн туслалцаа ба өмгөөллийн үйлчилгээ үзүүлэгчдийн холбооноос баталсан “Эрүүгийн хэрэгт хууль зүй үйлчилгээ үзүүлж, төлөөлөхөд хэрэгжүүлэх гүйцэтгэлийн тухай зөвлөмж” (НҮБ-ын үйл ажиллагааны загвар стандарт)	Олон Улсын Эрх Зүйн Сангаас боловсруулсан “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эхний үе шатанд үйлчлүүлэгчийг төлөөлөхөд баримтлах гүйцэтгэлийн минимум стандарт” (ОУЭЗС-ийн Непал, Тунис, Афганистан ба Баруун эргийн салбарууд)
-----------	--	--	---

Стандарт	2.2.1. Хуульч үйлчлүүлэгчийг зорилгоор суллах холбогдох шүүхэд хэргийн нөхцөл байдлын талаарх мэдэгдэл, хууль зүйн шаардлагыг хүргүүлэх бэлтгэл ажлыг хийж ажиллана.	2.1-р Зааварчилгаа “Шүүхийн өмнөх шатанд суллахтай холбогдуулан хийх өмгөөлөгчийн ерөнхий үүрэг.” “Өмгөөлөгч үйлчлүүлэгчид хамгийн таатай, зүй зохистой аргаар түүнийг шүүхийн өмнөх шатанд суллахад	P.2: Өмгөөлөгч үйлчлүүлэгчид хамгийн таатай, зүй зохистой аргаар түүнийг шүүхийн өмнөх шатанд суллахад бүх арга хэмжээг авч ажиллана. Хуульч үйлчлүүлэгчийн гэр бүл, хувийн байдал ба бусад хүчин зүйлсийг батлан
----------	--	--	---

шаардлагатай бүх арга даалтын хуралдаанд хэмжээг авч ажиллана. танилцуулж, суллагдсан 2.3-р Зааварчилгаа тохиолдолд дараагийн шүүх “Шүүхийн өмнөх шатанд хуралдаанд ирж оролцохыг суллах Хэрэг хянан илтгэнэ. шийдвэрлэх ажиллагаа”

2.2.7. Хуульч хэрэгт (а) Хуульч цугларсан баримт үйлчлүүлэгчийг суллах мэдээллийн үндсэн дээр зорилгоор холбогдох хамгийн хөнгөн таслан шүүхэд хэргийн нөхцөл сэргийлэх арга хэмжээ байдлын талаарх авахыг зорьж ажиллана. мэдэгдэл, хууль зүйн шаардлагыг хүргүүлэх бүх бэлтгэл ажлыг хангасан байна.

3-р дүрс Эрүүгийн хэрэгт хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэх үйл ажиллагаанд баримтлах зарчмууд		
Сонгосон хуулийн хэм хэмжээ	Үйл ажиллагааны зарчмууд	Хэлэлцүүлэг
<ul style="list-style-type: none"> Хуульч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүх үе шатанд өмгөөлөгчтэй чөлөөтэй, ганцаарчилж уулзах эрх Гэм буруугаа хүлээхгүй байх эрх Үндэслэлгүйгээр баривчлагдах, цагдан хоригдох эсхүл дур мэдэн шүүхийн өмнөх шатанд цагдан хорихоос ангид байх эрх Үйлчлүүлэгчийн хууль ёсны эрх, ашгийг хамгаалах өмгөөлөгч авах эрх 	<p>1. Эрт төлөөлөх - Хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэгч үйлчлүүлэгчийг баривчлагдах үед, баривчлагдсан даруйд эсхүл цагдан хоригдоход, мөн үйлчлүүлэгчийг мэдүүлэг өгөхөөс өмнө түүнтэй уулзахыг зорих бөгөөд тухайн хэрэгт томилогдсоноос хойш 24 цагийн дотор үйлчлүүлэгчтэй уулзаж зөвлөгөө өгнө.</p> <p>2. Үйлчлүүлэгч төвтэй өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх - Хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэгч үйлчлүүлэгчид бүрэн гүйцэд зөвлөгөө өгч, үйлчлүүлэгчийг хэрэгт хамааралтай чухал шийдвэрийг гаргахад туслаж дэмжих үүрэгтэй.</p> <p>3. Шүүхийн өмнөх шатанд эрх чөлөөтэй байх</p>	<p>Хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэгч үйлчлүүлэгчийг баривчлагдсанаас хойш цаг алдалгүй төлөөлж, түүнтэй ганцаарчлан уулзаж, хэрэгт ач холбогдол бүхий зөвлөгөөг өгсгөнөөр өөрийн үйлчлүүлэгчийн зорилго, амьдрал, гэр бүл, хувийн байдалтай илүү сайн танилцах боломж бүрддэг. Энэ нь эргээд дараах үр дагаврыг бий болгоно:</p> <ul style="list-style-type: none"> Үйлчлүүлэгчийн гэр бүл, хувийн ба нийгмийн байдал болон хэргийн нөхцөл байдалд тулгуурлан түүнд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авахаас сэргийлэх эсхүл суллагдах нөхцлийг бүрдүүлэх. Үйлчлүүлэгчид эрхийг нь тайлбарлаж, цагдаагийн газар мэдүүлэг өгөх зэрэг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үеэр гарч болох эрхийн зөрчил, эрсдлээс сэргийлж хамгаалах. <p>Үйлчлүүлэгчтэй нэн даруй уулзаж, үйлчлүүлэгчийг шүүхийн өмнөх шатанд суллах эл ажиллагааг одоогоор бүх гүйцэтгэлийн стандартад тусгаж хэрэгжүүлж байна. Өмгөөлөгч үйлчлүүлэгчийг түргэн шуурхай төлөөлж, таслан сэргийлэх арга хэмжээ авах шүүх хуралдаан болохоос өмнө түүний эрх ашгийг хамгаалбал үйлчлүүлэгч шүүхийн өмнөх шатанд эрх чөлөөтэй байх эрхээ эдлэх нөхцөл</p>

	<p>эрхийг хангах - Хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэгч үйлчлүүлэгчийг шүүхийн өмнөх шатанд суллах арга хэмжээг хамгийн боломжит эрт ба хэргийн бүхий л хугацаанд авч ажиллах үүрэгтэй.</p>	<p>бүрдэнэ. Мөн шүүх хурлын өмнө суллагдсан үйлчлүүлэгч хэргийг өөрт ашигтай байдлаар шийдвэрлэхэд туслалцаа өгч, шаардлагагүй тохиолдолд цагдан хоригдож, аливаа хүсэлт гаргахад цаг хугацаа алдахгүйгээс гадна цаашид арай хөнгөн ял хүлээх магадлал тун их.</p> <p>Эцэст нь, хууль тогтоомж, ёс зүйн дүрмийг чанд баримтлах замаар эрүүгийн хэрэгт хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэгч нь өөрийн үйлчлүүлэгчид үйлчлүүлэгч төвтэй буюу үйлчлүүлэгчийн хүсэл зориг, зорилгыг тусгасан өмгөөллийн үйлчилгээг үзүүлэх үүрэг хүлээдэг. Учир нь хууль зүйн туслалцаа үзүүлэгч өөрийн үйлчлүүлэгчийн зуучлагчийн үүргийг гүйцэтгэдэг нэгэн. Иймд одоогийн хэрэгжиж буй бүх гүйцэтгэлийн стандартад үйлчлүүлэгч хуулийн дагуу эдлэж болох бүх эрх, боломжийн талаар ойлгож, улмаар ашиг сонирхол болоод хүсэл зоригоо өөрөө тодорхойлоход өөрийн үйлчлүүлэгчид хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүх үе шатанд хууль зүйн зөвлөгөөг бүрэн гүйцэд өгч ажиллах эрүүгийн хэрэгт хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэгчийн үүргийг тусгасан болно.</p>
<p>Хараат бус байдлаар яллагдсан хэргийнхээ үйл баримтыг судлан шинжиж, өөрийгөө өмгөөлөх ба өмгөөлүүлэх эрх</p>	<p>4. Хараат бус байдлаар үйл баримтыг судлан шинжих нөхцлийг бүрдүүлэхэд оролцох – Хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэгч хэргийн газар очиж танилцах, боломжит бүх гэрчүүдтэй уулзаж ярилцах зэргээр бие дааж үйл баримтыг судлан шинжих үүрэгтэй.</p>	<p>Үйл баримтыг судлан шинжих хараат бус ажиллагаа нь гэм бурууг тогтоох шүүх хуралдаанд үйлчлүүлэгчийг төлөөлж, түүний байр суурийг хамгаалах урьдчилсан нөхцөл болдог. Ийнхүү хэргийн талаарх үйл баримтыг бие дааж судлан шинжлээгүйн улмаас яллагчийн байр суурийг үгүйсгэж няцаах, үйлчлүүлэгчийг өмгөөлөх хүчтэй хууль зүйн үндэслэл гаргах боломжгүй бөгөөд хууль зүйн туслалцаа үзүүлэгчийн өмгөөллийн ажиллагаа зөвхөн хууль сахиулагч эсхүл шүүхэд цугларсан үйл баримтаар хязгаарлаж буй явдал юм. Үйл баримтыг судлан шинжлэснээр хэргийн үр дагаварт маш их үр нөлөө үзүүлдэгийг ийм төрлийн хараат бус ажиллагааг хүлээн зөвшөөрч хэрэгжүүлдэг улс орнуудын туршлага болон үйл баримтыг судлан шинжлэх ажиллагааны нөлөөллийн судалгаанаас харж болно. Иймд хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэхэд баримтлах гүйцэтгэлийн стандартад үйл баримтыг судлан шинжлэх талаар тусгах нь зүйтэй гэдгийг олон улсад нэгэнтээ хүлээн зөвшөөрсөн болно.</p>
<p>• Бэлтгэл ажлыг сайтар хангаж,</p>	<p>5. Бэлтгэл ажлыг сайтар хангах -</p>	<p>Хуулиар яллагдагчдад иж бүрэн хууль зүй, өмгөөллийн үйлчилгээг үзүүлэх цаг хугацаа,</p>

<p>өөрийгөө өмгөөлөх ба өмгөөлүүлэх эрх</p> <ul style="list-style-type: none"> Хараат бус шүүхээр эрхээ бүрэн ба шударгаар тогтоолгох эрх 	<p>Хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэгч үйлчлүүлэгчийг өмгөөлөхдөө уялдаа холбоо бүхий, өндөр бүтээмжтэй ба иж бүрэн төлөвлөгөө, стратегийг гаргаж, шүүх хуралдаан тус бүрийн бэлтгэл ажлыг хариуцлагатай бэлтгэж ажиллана.</p> <p>6. Шинжээчийн оролцоог хангах - Хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэгч шаардлагатай ба боломжтой тохиолдолд шинжээч ба гэрчийг оролцуулна.</p> <p>7. Шүүхийн өмнөх шатны ажиллагаанд оролцох – өмгөөлөгч материаллаг болон процессийн эрх зүйн хэм хэмжээг ур чадвар, туршлагадаа тулгуурлан зөв ба оновчтой хэрэглэх замаар үйлчлүүлэгчид ашигтай байж болохуйц бүхий л гомдол, хүсэлтийг цаг тухайд нь гаргах үүрэгтэй.</p>	<p>нөөц бололцоогоор хангах үүргийг төр засагт хуваарилсан хэрнээ эрүүгийн хэрэгт хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэгч тухайн өөрт ногдсон цаг хугацаа, нөөц бололцоог бүрэн ашиглаж, бэлтгэл ажлыг хангаж чадахгүй бол хуулийн ийм зүйл заалтууд үр нөлөөгүй үлдэнэ. Өмгөөллийн цогц стратеги төлөвлөгөөг боловсруулж, шүүх хуралдаан, хүсэлт гомдол зэргийг оновчтой ашиглах замаар өөрийн стратеги төлөвлөгөөг улам боловсронгуй болгодог хууль зүйн туслалцаа үзүүлэгчид өөрийн үйлчлүүлэгчид илүү шударга байдлыг тогтоохын зэрэгцээ үйлчлүүлэгчид илүү ашигтай үр дагаврыг бий болгох давуу талтай. Үйлчлүүлэгчийн хууль ёсны ашиг сонирхол, эрхийг хамгаалахын тулд дээрх үзэл санаа болон сэтгэл судлал, сэтгэц эмгэг судлалын шинжээчийг оролцуулж дүгнэлт гаргуулах талаарх зохицуулалтыг одоогоор мөрдөгдөж буй бүх гүйцэтгэлийн стандартад тусгасан байна. Түүнчлэн, өнөөгийн бүх гүйцэтгэлийн стандартад хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэгчийг хуулийн хүрээнд зөвшөөрөгдсөн шаардлагатай бүх хүсэлт, гомдол, үндэслэл тайлбарыг гаргах үүрэгтэй хэмээн тусгасан болно. Энэ бол хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэгчийн зүгээс үйлчлүүлэгчид аливаа сөрөг үр дагавар, санкц үүсэх эсхүл давхар шийтгэл ногдуулахаас ангид байхаас сэргийлэх хууль зүйн арга хэрэгсэл билээ.</p>
<ul style="list-style-type: none"> Гэрчээс асуулт асуух болон нүүрэлдүүлж мэдүүлэг авах эрх. Шаардлагатай процессын ажиллагааг явуулах эрх. 	<p>8. Шүүхийн шатанд үйлчлүүлэгчийг хамгаалах – Хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэгч тодорхой, оновчтой, хүчтэй үндэслэлүүдийг гаргаж, хууль болон үйл баримтуудыг зөв хэрэглэх, гэрчүүдэд зүй зохистой, оновчтой асуултыг тавих үүрэгтэй.</p>	<p>Үйлчлүүлэгчийн байр суурийг хамгаалах гэрчүүдийг олж, мэдүүлэг авах, бусад гэрчүүдтэй нүүрэлдүүлэх ажиллагаа бол хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд яллах талын байр суурийг үгүйсгэж няцаах, улмаар шударга ёсыг тогтоож, гэм буруугүйг нотлоход гүйцэтгэх хууль зүй, өмгөөллийн үйлчилгээ үзүүлэгчийн үндсэн үүрэг юм. Одоогийн бүх гүйцэтгэлийн стандартад хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэгчийг нээлтийн ба хаалтын үндэслэлийг танилцуулж, яллах талын байр суурийг няцааж хэрэгсэхгүй болгох үүрэгтэй байхаар тусгажээ.</p>
<ul style="list-style-type: none"> Халдашгүй байх эрх хэрцгий, хүмүүнлэг бус, 	<p>9. Ял оногдуулах бүхий л нөхцөл байдалд оролцох /эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх, хөнгөрүүлэх</p>	<p>Эрүүгийн хэрэгт хамгийн хөнгөн ял шийтгэл ногдуулахаар үйлчлүүлэгчийг өмгөөлж буй хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэгч эрх зүйн зайлшгүй процесс</p>

<p>доромжлон гутаасан харьцаанаас ангид байх эрх</p> <ul style="list-style-type: none"> • Хэргийг хэрэгсэхгүй болгох, ял шийтгэлээс чөлөөлөх тухай давж заалдах. 	<p>Г.М. - эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх, хөнгөрүүлэх, хамгийн бага эрүүгийн хариуцлагыг оногдуулах нөхцөлийг судлах, үйлчлүүлэгчийг хамгаалах, боломжтой бол эрүүгийн хариуцлага дундаас сонгох боломжийг шүүгчид бий болгож хамгийн бага ялыг оногдуулах боломжийг танилцуулах.</p> <p>10. Хэргийг давж заалдах - цаг алдахгүйгээр давж заалдах, хяналтын шатанд гомдол гаргах, үйлчлүүлэгчийн эрх, ашиг сонирхлыг зөрчсөн байж болзошгүй бүхий л асуудлыг хууль тогтоомжийн хүрээнд хөндөж танилцуулах.</p>	<p>явуулалгүйгээр үйлчлүүлэгчийн халдашгүй байх эрхийн зөрчлөөс сэргийлэхээс гадна аливаа хууль бус хэрцгий шийтгэлээс ангид байх баталгааг хангадаг.</p> <p>Эрх чөлөөтэй, халдашгүй байх эрх нь ял шийтгэлээс өмгөөлөх хууль зүйн туслалцаа үзүүлэгчийн үүрэгтэй салшгүй холбоотой тул эл үүрэг бүх гүйцэтгэлийн стандартад тусгалаа олсон болно. Яг үүнтэй ижил, яллагдагчийн давж заалдах эрхийг олон улсын эрх зүйн хэм хэмжээгээр нийтээр хүлээн зөвшөөрсөн ба санал нэгтгэйгээр дэлхийн улс орнууд бүгд өөрсдийн гүйцэтгэлийн стандартад тусгасан байна. Хэргийн материалыг нягт нямбай хадгалж, дараагийн буюу хяналтын шатны шүүхэд гомдол гаргахад хууль зүйн туслалцаа үзүүлэгчид өөрийн үйлчлүүлэгчийн эрхийг дараа хамгаалж, хэргийг шударга шүүхээр шүүлгэх, анхан шатны хууль зүйн алдааг дараагийн шатны шүүхээр хянуулж шийдвэрлүүлэх боломжтой байна.</p>
---	--	--

III-Р ХЭСЭГ

Бид чанарыг хэрхэн үнэлэх вэ?

- **Эрүүгийн хэрэгт хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэгчдийн олон улсын нийгэмлэг** чанарыг хэмжиж, үнэлгээ өгөх замаар эх үүсвэрийг бүрдүүлж, тогтолцоог шинэчлэхийн зэрэгцээ үйлчлүүлэгчид хүргэх үйлчилгээ туслалцааны чанарыг тогтмол сайжруулах боломжтой.

- Эдүгээ эрүүгийн хэрэгт хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэгчид, өмгөөлөгчид төдийгүй хууль зүйн мэргэжлийн туслалцааны тогтолцоо бүхэлдээ өмгөөллийн үйл ажиллагаан дахь процессын үнэлгээ болон зардал-үр дагаврын үнэлгээний аргачлалыг тоон ба чанарын үзүүлэлтийн үндсэн дээр боловсруулж, ашиглах нь түгээмэл болж байна.

- Хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэгчдийн олон улсын нийгэмлэг хамтарч дэлхийн бүх улс орнуудын хэрэгцээг хангаж

чадахуйц чанарын шаардлагыг хэмжих багц үзүүлэлтийг нэг мөр боловсруулж батлах шаардлагатай байна.

Чанарын баталгааг бий болгох

Чанарыг тодорхойлсны дараагийн алхам бол түүнийг хэмжих аргачлалыг тогтоох явдал юм. Энэ тайлангийн хүрээнд хэмжүүрийг өргөн утгаар нь эрүүгийн хууль зүйн мэргэжлийн туслалцааны чанар буюу үнэ цэнийг тодорхой шалгуурын үндсэн дээр системчлэн тодорхойлох явдал гэж ойлгож хэрэглэх ба чанарын үнэлгээнд нэн чухалд тооцогддог. Үнэлгээ хийхгүйгээр хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэгч өөрийн үйлчлүүлэгчийг чанарын өндөр төвшинд төлөөлж, түүний эрх ашгийг зохих ёсоор хамгаалах үүргээ биелүүлж чадсан эсэхийг тогтоох боломжгүй.

Үнэлгээний тусламжтайгаар хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэгч дан ганц хуульчдад төдийгүй хуулийн байгууллага ба хуулийн тогтолцоонд бүхэлдээ тогтмол сайжралтыг хийнэ. Үнэлгээ хийхийн тулд эхлээд чанарын үзүүлэлтийг хэмжих шаардлага үүсдэг учраас уг тайлангийн хэсэгт чанарын хэмжүүр нь эрүүгийн хууль зүйн мэргэжлийн туслалцааны нийгэмлэгт ямар өндөр ач холбогдолтойг тайлбарласан болно. Үүний дараа эрүүгийн хууль зүйн мэргэжлийн туслалцаатай холбоотой төрөл бүрийн үнэлгээнд хэмжүүрийг хэрхэн ашиглаж байгааг авч үзнэ. Эцэст нь хууль зүйн туслалцаа үзүүлэгчид үнэлгээний хэрэгцээг хангахад чиглэсэн чанарыг хэмжих нэгж болох хэмжигдэхүүнүүдийг хэрхэн сонгох талаар танилцуулсан болно.

Яагаад үнэлэх гэж?

Саяхныг хүртэл нэгэн судлаачийн дүгнэснээр олон улс дахь эрүүгийн хууль зүйн мэргэжлийн туслалцаа нь “ ямар ч баримтгүй бүс” Өөр нэгэн судлаач “төлбөрийн чадваргүй яллагдагчдад хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэх салбарт шийдвэр гаргахдаа юунд үндэслэдэг, юуг баримталдаг талаар мэдээлэл судалгаа тун хомс” байдаг тухай тэмдэглэсэн удаатай.

Гэвч энэ дүгнэлт төдийлөн бодит байдалд нийцэхгүй. Учир нь хууль зүйн туслалцаа үзүүлэгчдэд эрүүгийн хууль зүйн мэргэжлийн туслалцааны үйлчилгээнд бэлэн олохгүй өгөгдлийг цуглуулж, дүн шинжилгээ хийх шаардлагатай байсныг бид харгалзаж үзэх хэрэгтэй. Мөн эрүүгийн хэрэгт хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэгчид хууль зүйн мэргэжлийн туслалцааны бүтэц, зохион байгуулалт болон тогтолцоо, мөн эх үүсвэр, нөөцийн хуваарилалт, практик дээр гардаг хүлээлтийн талаар шийдвэр гаргахыг зорьж ирсэнийг үгүйсгэхгүй. Ингэхдээ тэд уламжлалт эрх зүйн зан заншил болоод нийтлэг хууль зүйн практикийн туршлагыг судалсан ажээ. Энэ нь эргээд үр нөлөө үзүүлээгүй гэж дүгнэх нь ташаа ойлголт юм.

Эрүүгийн хэрэгт хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэгчдийн нийгэмлэгийн өмнөх туршлага нь арвин их эрдэм мэдлэг, туршлагын булаг болсон юм.

Гэвч эрүүгийн хэрэгт хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэхтэй холбоотойгоор тогтолцоо болон хувь хүний үйл ажиллагааны төвшинд нийтлэг гардаг хүндрэл бэрхшээлүүд нь өгөгдлийг тодорхойлж, түүнийг хэмжиж дүгнэлт гаргах асуудал юм. Үнэлгээ, хэмжүүрийн өгөгдөл байхгүй үед эрүүгийн хэрэгт хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэхэд дараах тулгамдсан асуудлууд түгээмэл гардагийг зарим улс орнуудын жишгээс харж болно:

- **Санхүүжилт** – тодруулбал, хууль зүйн мэргэжлийн туслалцааны нийгэмлэгийн хамгийн түгээмэл бэрхшээл бол санхүүжилт хүрэлцэхгүй байх асуудал юм. Нэгэн шинжээчийн дүгнэснээр эрүүгийн хууль зүйн мэргэжлийн туслалцааны тогтолцоон дахь санхүүгийн эх үүсвэрийн дутмаг байдал нь үр нөлөө бүхий хэмжүүр болон үнэлгээ байхгүйтэй шууд холбоотой байдаг байна. Тэрээр “Төлбөрийн чадваргүй яллагдагчдад хууль зүй, өмгөөллийн үйлчилгээ үзүүлдэг тогтолцоог санхүүжилтгүй гэх үзэл давамгайлдаг боловч бодит байдал дээр тус салбарт ийм үйлчилгээний зардал хэд байгаа вэ, цаашид хэд байх шаардлагатай болон аль үйл ажиллагааны зардлыг хасахад үйлчилгээний чанарт сөргөөр нөлөөлүүлэхгүй вэ зэргийг нарийн тооцоолж гаргах арга хэрэгсэл байхгүй”. Өөрийн гүйцэтгэдэг үйл ажиллагаа болон тухайн үйл ажиллагааг үйлчлүүлэгчид ямар үр дүнг үзүүлдэг талаар тооцоолдоггүй, нөгөөтээгүүр хэт их ажлын ачааллын улмаас үйлчлүүлэгчид түүний үйл ажиллагаа хэрхэн сөргөөр нөлөөлж байгааг тооцоолж ажлын хуваарилалтыг зөв гаргаж чадахгүй өмгөөлөгч хүн өөрт буй бүх боломжит нөөцийг зүй зохистой ашиглаж, чанарын өндөр төвшинд үйлчилгээ үзүүлэхэд бэрхшээлтэй.

• **Бүтцийн шинэчлэл** гэдгийг бүтэн цагийн улсын өмгөөллийн ажлын байрыг бий болгохоос эхлээд төлбөрийн чадваргүй яллагдагчдад хууль зүйн туслалцаа үзүүлэх хүсэлтэй хувийн өмгөөлөгчдийг томилох хүртэл асуудлыг бүрэн хамардаг. Хууль зүйн туслалцааны бүтцэд шинэчлэлт хийхийг санаачлагчид ямагт эл төрлийн үйл ажиллагааны чанар ба түүнд хуваарилсан зардлыг үр нөлөөтэй зарцуулах нь чухал гэж тайлбарладаг боловч чанар ба зардлын оновчтой тооцооллыг хэмжиж үнэлэхгүйгээр боловсронгуй болгоход бэрхшээл үүсдэг. Долоон жилийн туршид АНУ-ын хууль зүйн тогтолцооны гүйцэтгэлийг хэмжиж, үнэлгээ өгөх төлөвлөгөөг боловсруулах зорилгоор судалгаа хийсэн эрдэмтдийн нэг баг “төлбөрийн чадваргүй яллагдагчдад үзүүлэх өмгөөллийн салбарт эрүүл мэнд, халамжийн салбар гэх бусад томоохон салбарын адил тухайн үйл ажиллагаа өөрийн зорилгыг биелүүлж чадаж байгаа эсэхийг хэмжихэд чиглэсэн үзүүлэлтийг цуглуулж, дүн шинжилгээ хийх боломж бий. Өдөр бүр энэ үнэлгээний боломжийг бодитоор хэрэгжүүлээгүйн улмаас бид төлбөрийн чадваргүй иргэдэд үзүүлэх хууль зүй, өмгөөллийн үйлчилгээг илүү үр нөлөөтэй, боловсронгуй болгоход шаардлагатай хэрэгцээ, шинэчлэлийг сайжруулж чаддаггүй.”

• **Чанарын сайжруулалт.** Энэ тайланд өмнө дурьдсанчлан чанар нь гүйцэтгэлийг хэмжих чадвараас хамаарна. Өөрөөр хэлбэл, чанарыг тодорхойлж сайжруулахын тулд гүйцэтгэлийн үнэлгээний өгөгдөлд дүн шинжилгээ хийж, гүйцэтгэлийн аль хэсэгт сайжруулалт хийх шаардлагатайг тогтоох замаар чанарын жишгийг тогтоож, эл жишигт хүрэх үйл явцыг нарийн тодорхойлох юм. Өгөгдөлд суурилсан үйлчилгээний чанарын баталгааны стратегийг боловсруулж хэрэгжүүлэн, үйлчлүүлэгчийн хүртэх үр нөлөө, давуу байдлыг эрс сайжруулж, амжилттай яваа эрүүл мэнд, иргэний нисэх хүчин гэх мэт бусад мэргэжлийн салбараас

хууль зүйн мэргэжлийн туслалцааны салбарыг суралцаж болох зүйлсийн талаар судалгаа хийжээ. Судлаачдын үзсэнээр “Өгөгдөлд суурилсан сайжруулалтыг хийхийн тулд оролцогчид өгөгдлийг цуглуулж, алдаа дутагдлыг илрүүлэхийн зэрэгцээ баримттай санал хүсэлтийг хүлээн авах бөгөөд гагцхүү эл үйлдлүүдийг нягт нямбай хийснээр үр дүнгээ нэмэгдүүлсэн шинэчлэлийг хийх аж”.

” Эрүүгийн хэрэгт хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэгчид ийнхүү тоонд суурилсан өгөгдлийн үндсэн дээр үйл ажиллагаагаа хэмжиж дүгнэхэд мэргэжлийн бусад онцлог шинж чанарыг үл харгалзсан өнгөцхөн дүгнэлт гарна гэж буруу ойлгодог. Гэвч тоолох боломжтой буюу ийм тоонд суурилсан “квантитатив” өгөгдлийг шүүхийн бүртгэл ба хуулийн фирм зэрэг байгууллагуудын удирдлагын системд ашиглагдаас гадна тоон өгөгдөл бол эрүүгийн хууль зүйн мэргэжлийн туслалцаа, үр дүн, үр дагаварт үнэлгээ өгөх хэмжүүрийн хоёр өгөгдлийн ердөө нэг л төрөл юм.

Тоон өгөгдлүүд “аливаа үйл явдал эсхүл түүний үндсэн шинж чанарыг илэрхийлдэг” бол өгөгдлийн эх үүсвэр болох ярилцлага, ажиглалт ба бичиг баримт зэрэг нь тухайн тоон үзүүлэлтийн үндэслэлийг тогтоож баталгаажуулахад чухал ач холбогдолтой. Өөр нэг хууль зүйн мэргэжлийн туслалцааны судалгааны баг “өмгөөлөгч үйлчлүүлэгчтэйгээ хэрхэн харилцаж байгаа гэх мэт тоолох боломжгүй асуудлыг чанарын үзүүлэлтийг ашиглаж болно. Чанар ба тоон үзүүлэлтүүдийн үр дүнг хамтад нь хэмжиж дүгнэснээр тухайн харилцааг өргөн хүрээнд бүрэн гүйцэд тодорхойлж болдог.”

Эрүүгийн хэрэгт хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэгчид чанарыг хэмжиж, үнэлгээ хийхийг мэргэжлийн дүгнэлтийг үл харгалзан зөвхөн тоон өгөгдөлд суурилна гэж бодох нь өөрөө өрөөсгөл ойлголт юм. Тоолох боломжтой тоон

өгөгдлийг шүүхийн бүртгэл, хуулийн фирмийн хэрэг бүртгэл, удирдлагын тогтолцоонд нийтлэг хэрэглэдэг төдийгүй эрүүгийн хэрэгт хууль зүйн мэргэжлийн туслалцаанд хамаарах нэн чухал үйл ажиллагаа, үр дүн болоод түүний үр дагаврыг хэмжих суурь болсон хоёр өгөгдлийн ердөө нэг төрөл билээ. Нөгөөтгээгүүр аливаа үйл явдлын шинж чанар эсхүл туршлагыг илэрхийлдэг чанарын өгөгдлүүд ялгаагүй чухал бөгөөд түүний эх үүсвэрт ярилцлага,

ажиглалт ба баримт бичиг зэрэг зүйлс багтана. Нэгэн хууль зүйн мэргэжлийн туслалцааны судалгааны багийн тайлбарласанчлан, чанарын үзүүлэлтийг харгалзаж үзсэнээр өмгөөлөгч ба үйлчлүүлэгчийн хоорондын харилцаа гэх мэт тоогоор илэрхийлэгдэх боломжгүй харилцааг тодорхойлно. Тоон үзүүлэлт болон чанарын үзүүлэлтийг хэмжиж үнэлгээ өгөхөд үнэлгээ хийж буй тухайн харилцааны дүгнэлт илүү ойлгомжтой, бодитой байх юм.

“ Бид гүйцэтгэлийн стандартыг анх 2003 онд хийж эхэлсэн. Тэр үед олон улсын стандартыг судалж, Афганистан улсын хууль тогтоомж болон өөрийн байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлж байв. Стандарт гэдэгт сайтар ярилцаж уулзах, саатуулах, цагдан хорих байр ба хорих ангид очиж уулзах, үйлчлүүлэгчийг өмгөөлөхөд туслах аливаа үйл баримтыг судлан шинжлэх, гэрчдийг нүүрэлдүүлж мэдүүлэг авахаас эхлээд өөр хийх шаардлагатай маш олон үйл ажиллагаанууд нэмж багтсан.

Манай байгууллага өсөн томрохын хэрээр үйл ажиллагаа маань илүү боловсронгуй болсны үр дүнд бид одоо Афганистан улс дахь эрүүгийн хэрэгт үзүүлдэг хууль зүй, өмгөөллийн үйлчилгээний жишигийг тогтоож чадсан юм. Байгууллагын дотоод бүтэц, зохион байгуулалтад ч мөн адил өөрчлөлт оров. Одоо бид хэмжүүр болон үнэлгээ хариуцсан хэлтэстэй. Тус хэлтэс өөрсдийн хуульч, өмгөөлөгчдийнхөө ажилд үнэлгээ өгөх чиг үүрэгтэйгээр ажиллах бөгөөд уг чиг үүргээ хэрэгжүүлэхийн тулд байгууллагын хэргийн удирдлагын тогтолцоог үнэлгээний хэрэгсэл болгож ашигладаг тул маш их хэмжээний, олон төрлийн хэмжигдэхүүнийг тогтмол илрүүлж ажилладаг. Нэг өмгөөлөгчид хэдэн хэрэг ногдож байна? Хэргийн хүнд, ярвигтай байдал болон ажлын ачаалал нь хуульчийн туширлагатай нийцэж байгаа эсэх? Хуульчийн үйл ажиллагааны улмаас ямар төрлийн үр дүн бий болж, үйлчлүүлэгчид ямар үр дагавар очиж байгаа вэ? Эдгээр асуултуудад хариулт өгч, бид хуульчдынхаа үйл ажиллагааг сайжруулдагаас гадна хуульчдын үйл ажиллагааг тоон үзүүлэлтээр хооронд нь харьцуулдаг.

Түүнчлэн хэмжүүр ба үнэлгээний баг “газар дээрх” үнэлгээг хийдэг. Өөрөөр хэлбэл тус хэлтсийн төлөөлөгчид орон нутагт очиж, хууль зүйн мэргэжлийн үйл ажиллагааны стандартын хэрэгжилтийг шалгах хяналтын жагсаалт буюу чеклистийг ашиглан тэндхийн өмгөөлөгчдийн үйл ажиллагаа, хэргийн материалтай танилцаж үнэлгээ өгнө. Мөн тус багийнхан шүүхэд очиж, шүүгч, прокурорууд, үйлчлүүлэгчтэй уулзан хуульчид юун дээр сайн ажиллаж байгаа, харин юуг сайжруулах шаардлагатай талаар тодруулж асуудаг юм. Энэ бүх мэдээллийг бид хуульчдын үйл ажиллагаанд өгөх үнэлгээнд хэрэглэж, улмаар тус үнэлгээний дүгнэлтийг сургалтын хэлтэст хүргүүлж, сургалтын хэлтэс нь хуульчдад эзэмшвэл зохих мэдлэг, ур чадварыг хөгжүүлэх сургалтыг зохион байгуулдаг. Бид хуульчдыг илүү хариуцлагатай болгож чадна. Бид тэднийг өсөн дэвшихэд туслаж чадна.



Бид улам л сайжраад байгаа.” Афганистан дахь Олон улсын эрх зүйн сангийн Мэдээлэл хөгжлийн менежер Абдул Каюум Ахмадзай.

Эрүүгийн хэрэгт хууль зүйн мэргэжлийн туслалцааны хөтөлбөрт үнэлгээ өгөх

Маш олон улсад хууль зүйн мэргэжлийн туслалцааны үйлчилгээнд чанарыг хэмжиж, үнэлгээ өгөхийн ач холбогдлыг хүлээн зөвшөөрч, хууль зүйн туслалцааны тогтолцоог системчлэн сайжруулж, шаардлагатай нөөц, эх үүсвэрийг хангах арга хэмжээг авч эхэлснээс гадна өгөгдөлд суурилсан аргачлалын тусламжтайгаар чанарын баталгааг хангах явдал нэн чухал болохыг зөвшөөрч хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Эдүгээ эрүүгийн хууль зүйн мэргэжлийн туслалцааны нийгэмлэг

ОУЭЗС-ийн Баруун эрэг дэх салбараас зохион байгуулсан дугуй ширээний хэлэлцүүлэгт оролцогчид “Хууль зүйн мэргэжлийн туслалцааг эрт үзүүлэх” сэдвээр санал солилцож байгаа нь

үнэлгээний 3 үндсэн хэлбэрийг ашиглаж байна. Үнэлгээ өгөх хэлбэр тус бүрийн аргачлал, өгөгдлийн эх үүсвэр, хэмжигдэхүүн нь үнэлгээний шинж чанар ба зорилгоос хамаарч харилцан адилгүй байна.

- **Процессын үнэлгээний** хэмжүүрийн үр дүн – эрүүгийн хэрэгт хууль зүйн мэргэжлийн туслалцааны шууд бүтээгдэхүүн. Хэрэв, тухайлбал хүсэлт, гомдол гаргах хууль зүйн мэргэжлийн туслалцааны үйлчилгээ үзүүлэх бол тус үйлчилгээний үр дүн нь боловсруулж, хүргүүлсэн хүсэлт, гомдол байна. Процессын үнэлгээнд “тухайн хөтөлбөр зорилтот бүлэгт зөв үйлчилгээг амжилттай хүргэж чадсан эсэх” асуултад хариулахыг зорино. Эрүүгийн хэрэгт хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэгчийн үйл ажиллагаанд процессын үнэлгээ хийхэд хувь өмгөөлөгч гүйцэтгэлийн стандартыг бүрэн хэрэгжүүлсэн эсэхэд дүгнэлт хийнэ. Энгийн үгээр тайлбарлавал: өмгөөлөгч үйлчлүүлэгчийн нэрийн өмнөөс

зөв зүйлээ хийсэн үү?

Тухайлбал, процессын үнэлгээний жишээ болгож Их Британийн Англи, Уэльс болон Шотландын эрүүгийн хэргийн хууль зүй, өмгөөллийн үйлчилгээний чанарт

хийгдсэн үнэлгээг дурьдаж болох юм. Тусгайлан бэлтгэсэн хуулийн мэргэжилтнүүд нарийвчлан тогтоосон шалгуурын үндсэн дээр хууль зүйн мэргэжлийн туслалцааны өмгөөлөгчдийн хэргийн бүртгэлд аудитын шалгал хийх хэлбэрээр тус үнэлгээг хийсэн байна. Өөрөөр хэлбэл мэргэжлийн хуульчид өөрсдийн туршлагадаа суурилж, мэргэжил нэгтгүүдийнхээ үйл ажиллагаанд хяналт шалгалтын үнэлгээг хийж, тоонд суурилсан бус, харин үйл ажиллагааны чанарын өгөгдлийг цуглуулсанаараа онцлог юм. Ийнхүү тэд эрүүгийн хэрэгт үзүүлсэн хууль зүйн мэргэжлийн туслалцааны үр дүнд үйлчлүүлэгчид очсон нөлөөллийг чухалчилсан болно. Тодруулбал, үнэлгээчид өмгөөлөгч үйлчлүүлэгчтэй хэрхэн харилцсан, үйлчлүүлэгчээс холбогдох мэдээллийг хэрхэн авсан, үйлчлүүлэгчээс мэдээлэл авахад хэр их хүчин зүтгэл гаргаж ажилласан зэргийг харгалзаж үзсэн байна. Мэргэжлийн өмгөөлөгчид чанартай хууль зүйн мэргэжлийн туслалцаан дор юуг ойлгохыг мэдэж байдаг буюу чанартай өмгөөллийн жишиг загварыг мэдэх тул хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэгчид эл загварыг баримталсан эсэхэд үнэлгээ өгөхөд илүү дөхөм юм.

• **Үр дагаврын үнэлгээгээр** эрүүгийн хэрэгт хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэгчийн бодит практикт үзүүлсэн тодорхой өөрчлөлтүүдийг хэмжинэ. Тухайлбал, хууль зүйн туслалцаа үзүүлэгч үйлчлүүлэгчийг шүүхийн өмнөх шатанд суллах арга хэмжээ авах бол түүний үр дагавар нь үйлчлүүлэгчийг сулласан явдал байж болох юм. Үр дагаврын үнэлгээний үр дүнд тухайн үйл ажиллагаа хүссэн үр дагаврыг бий болгосон эсэхэд дүгнэлт хийнэ. Өөрөөр хэлбэл, хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэгч үйлчлүүлэгчид зүй зохистой үр дүнгээ бий болгосон уу, тухайн үйл ажиллагаа ямар өөрчлөлт авчирсанд үнэлгээ өгдөг. Үр дагаврын үнэлгээнд гүйцэтгэлийн стандартын хэрэгжилт гэхээс илүүтэйгээр түүнийг дагаж мөрдсөнөөр гарах

зорилтот үр дагавар, зорилтууд чухал. Эдгээр зорилтуудыг ихэнхдээ хууль зүйн мэргэжлийн туслалцааны үйл ажиллагааны эрхэм зорилго, стратегийн төлөвлөгөө аль эсхүл үйлчлүүлэгчийн нэрийн өмнөөс түүний эрх ашгийг хамгаалж үйлчилгээний үр дүнг тусгасан бусад баримт бичигт тодорхойлсон байна.

Нэг талаараа, хууль зүйн мэргэжлийн туслалцааны үр дагавар тухайн өмгөөлөгч эсхүл өмгөөллийн багийн үйл ажиллагаанаас бүрэн ба шууд хамаардаггүй, харин шүүгч, шүүхийн тогтолцоо зэрэг гадаад хүчин зүйлсийн нийлбэр байх учраас үр дагаврын үнэлгээ хийхэд амаргүй. Жишээ нь: үйлчлүүлэгчийг шүүхийн өмнөх шатанд суллахад шаардлагатай бүхий л үйл ажиллагааг өмгөөлөгч хийсэн ч гэсэн суллах эсэх шийдвэрт прокурорын дүгнэлт, үйлчлүүлэгчийн хувийн байдал болон мэдээжийн хэрэг шүүгчийн шийдвэр нөлөөлнө. Өмгөөлөгчийн үйл ажиллагаа голдуу “туслах хүчин зүйл” болдог. Иймд үр дагаврын үнэлгээг үнэн зөв хийхийн тулд өмгөөлөгчийн үйл ажиллагаанаас гадна бусад хүчин зүйлсийг шалгаж, үнэлэх шаардлага бий.

Эрүүгийн хууль зүйн мэргэжлийн туслалцааны үйл ажиллагааны үр дүнд бодит амьдралд маш олон төрлийн үр дагаврыг бий болгох бололцоотой. Үүнд, дээр дурьдсанчлан шүүхийн өмнөх шатанд суллах зэрэг хамаарах ба зарим үр дагаврыг шүүхийн хэргийн бүртгэл дэх өгөгдлөөс судалж болно.

Хууль зүйн мэргэжлийн туслалцааны үзүүлэгчид үнэлгээний бүтцийг хэрхэн боловсруулж, гүйцэтгэхээ төдийлөн сайн мэдэхгүй байгаа бол эхлээд хэргийн үр дагавар ба мэдрэгдсэн үр дагаврыг хооронд нь ялгаж салгавал их хэрэгтэй. Хэргийн үр дагавар бол өмгөөлөгчийн үйл ажиллагааны улмаас тухайн хэрэгт бий болсон үр дагавар байх бөгөөд объектив ба гадаад хүчин зүйлсээр нотлох боломжтой өгөгдлүүдийн үндсэн дээр хэмжигдэнэ. Тухайлбал, хэргийг

хэрэгсэхгүй болгох, ял оногдуулах, хүнд ба хөнгөн ялын төрлийн хэмжээ гэх мэт. Үүнтэй харьцуулахад, мэдрэгдсэн үр дагавар гэдэгт үйлчлүүлэгч ба бусад этгээдэд мэдрэгдсэн, хүлээн авсан өөрчлөлтийн үндсэн дээр хэмжигдэх өмгөөлөгчийн үйл ажиллагааны улмаас бий болсон аливаа үр дагаврыг ойлгоно. Жишээ нь: өмгөөлөл, төлөөллийн үйл ажиллагаатай холбоотой үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж, хэргийг шийдвэрлэсэн байдал шударга байсан эсэх талаар үйлчлүүлэгчийн байр суурь, шударга шүүхэд итгэх олон нийтийн итгэл.

Хэргийн үр дагавар ба мэдрэгдсэн үр дагавар аль алиныг нь судалсан үнэлгээний нэг жишээ бол 2000 онд Шотланд улсын Хууль зүйн өмгөөллийн үйлчилгээний төрийн байгууллагын улсын өмгөөлөгчдийн үйлчилгээний чанарт хийсэн үнэлгээ юм. Уг үнэлгээг хийсэн баг нийт 2,600 хэргийн өмгөөлөгчдийн мэдээллийг цуглуулж, улсын өмгөөлөгчид болон хувийн өмгөөлөгчдийн үйл ажиллагааны үр дагаварт харьцуулалт хийсэн байна. Судалгааны хүрээнд гэм буруутайд тооцсон шийдвэр, хорих ял авсан үйлчлүүлэгчдийн тоо, хувь хэмжээ, үйлчлүүлэгчид ногдуулсан хорих ялын хэмжээ гэсэн үр дагавруудыг харгалзан үзжээ. Түүнчлэн, үнэлгээчид үйлчлүүлэгчтэй уулзаж, тэдний хэргийг нь төлөөлж өмгөөлсөн хууль зүйн туслалцаа үзүүлэгчдийн талаарх үйлчлүүлэгчийн саналыг сонсож, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж ба итгэлцлийн төвшинг тодорхойлов. Яг энэ тал дээр, процессын үнэлгээтэй харьцуулахад үнэлгээний баг хууль зүйн туслалцаа үзүүлэгчид ажлаа хэр гүйцэтгэснийг төдийлөн чухалчилж авч үзээгүй, харин өмгөөлөгчийн үйл ажиллагаа үйлчлүүлэгчид ямар үр дагавар үзүүлж байгааг судлан шинжлэхийг зорьсон юм. Илүү ойлгомжтойгоор хэлэхэд “Өмгөөлөгчид зорилтот үйлчилгээг үзүүлсэн уу биш, харин тус үйлчилгээ нь хүссэн үр дагаврыг бий болгосон уу?” гэдэг асуултын хариултыг олохоор үнэлгээ хийжээ.

• **Зардал ба үр ашгийн үнэлгээнд** хууль зүйн мэргэжлийн туслалцааны үр дагаврыг мөнгөн хэлбэрийн зардал, ашгийн хүрээнд судална. Зардал ба үр ашгийн дүн шинжилгээ нь үйл ажиллагааны үр дагаврыг мөнгөн хэлбэрт оруулж, эдгээр үр ашгийг үйл ажиллагааны зардалтай харьцуулдаг. Өөрөөр хэлбэл, тухайн үр дүн ашигтай байсан эсэхийг дүгнэдэг.

Анх 2012 онд АНУ-ын Техас мужын Вичита Каунтид бүтэн цагаар ажилладаг улсын өмгөөлөгчид болон тодорхой хэрэгт хуваарилагдсан хувийн өмгөөлөгчдийн үйл ажиллагааны зардлыг харьцуулах зорилгоор эл зардал ба үр дагаврын үнэлгээг хийж байжээ. Тус үнэлгээний багийнхан эхлээд шүүхийн өмнөх шатанд суллахад гарах зардал, шүүхийн өмнөх шатанд хэргийг хэрэгсэхгүй болгоход гарах зардал, хорих ял авсан үйлчлүүлэгчдийн тоо, хувь хэмжээ болон үйлчлүүлэгчийн авсан хорих ялын хэмжээ зэрэг үр дагаварт үнэлгээ өгөхийн тулд тоон өгөгдлийг цуглуулжээ. Үүний дараа үр дагаврыг мөнгөн дүнгээр илэрхийлж, улмаар улсын өмгөөлөгчийг үндсэн ажилтнаар ажлуулах эсхүл төрөл бүрийн үнэ тарифтай хувь өмгөөлөгчдийг томилж ажлуулах хоёрын аль нь мужын төсөвт илүү зардал багатай тусах талаар тооцоолсон байна. Үнэлгээний үр дүнд улсын өмгөөлөгчид хэргийг хэрэгсэхгүй болгох нь их байсан тул энэ нь эргээд мужын төсөвт хэргийг хянан шийдвэрлэх процессын зардлыг бууруулж, улмаар дараагийн процессын зардлыг хэмнэх боломж олгохоос гадна улсын өмгөөлөгчдийн үйлчлүүлэгчдийн цагдан хоригдсон хугацаа ч гэсэн бага байсан ажээ. Ийнхүү зарим зардлын хэмнэлтийг тооцоолсны дараагаар “улсын өмгөөлөгчдийг үндсэн ажилтнаар ажлуулдаг хууль зүйн туслалцааны төв нь нэг үйлчлүүлэгчид ногдох үнийн дүнгээр нийтдээ 204 ам.долларын зардлыг мужын төсвөөс хэмнэж, 160 ам.долларын цэвэр ашиг олдог буюу нэг хэрэгт нийт 364 ам.долларын ашиг олдог байна” хэмээн дүгнэв.



Бид юунд үнэлгээ өгөх вэ?

Дээрхээс дүгнэхэд, эрүүгийн хэрэгт үзүүлэх хууль зүйн мэргэжлийн туслалцааны бүх үнэлгээ нь хоорондоо ижил төстэй шинж чанарыг агуулж байна. Нэгт, эдгээр үнэлгээ нь бүгдээрээ гүйцэтгэлийн стандарт эсхүл үйл ажиллагааны зорилтуудыг эхлээд жишиг болгон тодорхойлсон байна. Хоёрт, эдгээр жишиг болгож тодорхойлсон стандарт эсхүл зорилтуудыг хэрэгжүүлсэн эсэхийг тогтоох өгөгдлийг цуглуулж дүгнэдэг. Үүний дараагаар эд өгөгдлийг хэрхэн ашигласнаас хамаарч хэмжигдэхүүний асуудал хөндөгдөх болно. Одоогоор өөрийн хууль зүйн мэргэжлийн туслалцааны тогтолцооны процесс, үр дагавар болон зардлын үр нөлөөтэй зарцуулалтыг хамарсан иж бүрэн

тоо цөөн байна. Эдгээрийн зарим нь үнэлгээ хийхэд ашиглах өгөгдөл, мэдээллийн баазад хялбар нэвтрэх, цуглуулах, дүн шинжилгээ хийх боломжийг олгох зорилгоор хэргийн удирдлагын тогтолцоог цахимжуулсан болно. Гэвч эрүүгийн хууль зүйн мэргэжлийн туслалцааны тогтолцоо, хууль зүйн туслалцаа үзүүлэгчид болон хувь өмгөөлөгчид хууль зүйн мэргэжлийн туслалцааны чанарын хэмжиж үнэлгээ өгөхөд шаардлагатай санхүүгийн болон бусад нөөц бололцоо хомс байдаг тул тухайн үйл ажиллагааны шинж чанар, зардал, үр ашгийн талаарх асуултад хариулахын тулд бүх боломжит өгөгдлийг бүрэн гүйцэд цуглуулж чаддаггүй.

ОУЭЗС-гийн Бауун эрэг дэх салбарын захирал Нэйл Граннам болон улсын өмгөөлөгчид Их Британийн хуульч, олон улсын мэргэжил нэгтнүүдийн хамтаар менторинг хөтөлбөрийн хүрээнд үйлчлүүлэгчийг өмгөөлөх стратегийг боловсруулж байна.

үнэлгээний төлөвлөгөөг хийхэд ашиглаж хэрэглэх хэмжигдэхүүний дэлгэрэнгүй жагсаалтыг боловсруулахад маш их цаг хугацаа, хүчээл зүтгэл гаргасан улс орнуудын

Харин тус тайлангаар бид дэлхий нийтээрээ нэгдсэн журмаар дагаж мөрдөх боломжтой, улс орон тус бүрийн онцлогт нийцсэн гүйцэтгэлийн стандартыг

боловсруулахыг зорьж байгаа билээ. Уг стандарт дээр өөрийн улс орны хууль эрх зүйн орчинд тохирсон байдлаар ашиглаж болох гүйцэтгэлийн багц хэмжигдэхүүнийг давхар хэрэглэвэл хууль зүйн мэргэжлийн туслалцааны чанарын шаардлага, баталгааг хангана.

“ Бид чанарыг хэрхэн үнэлэх вэ? Бид зөвхөн үр дүнд л анхаарлаа хандуулаад байж болохгүй. Заримдаа хамгийн сайн хуульчид ч гэсэн аймшигтай алдаа гаргадаг. Заримдаа чанартай ажлаагүй хэрнээ хөнгөн хэрэг авсан тулдаа л сайн дүн авдаг хуульчид ч байна. Ийм болохоор бид үр дүнгээс гадна үр дагаврыг давхар хардаг юм. “

Олон Улсын Эрх Зүйн Сангийн Непал улсын салбарыг хариуцсан захирал Ажсай Шанхар Жха

Ингэхдээ эхний үе шатанд эдгээр үнэлгээний хэмжигдэхүүн бүгд иж бүрэн, цогц байх шаардлагагүй гэдгийг анхаарвал зохино. Үүний оронд олон улсын хууль зүйн туслалцааны нийгэмлэг аливаа ажил үйлчилгээний чанарт үнэлгээ өгөх сонирхолтой бусад үйлчилгээ үзүүлэгчийн адилаар харьцангуй энгийн шалгуур үзүүлэлтийг сонгоход хангалттай. Хэмжигдэхүүн дараах үндсэн шалгуурыг хангасан тохиолдолд үнэлгээ хүссэн үр дүнгээ үзүүлнэ. Үүнд:

1. Хэрэгцээ шаардлага хангасан – Хэмжигдэхүүнийг сонгохдоо үнэлгээний хэрэгцээ шаардлагыг харгалзан үзэж, түүнд нийцүүлэх;
2. Биелэгдэх боломжтой – Цуглуулахад харьцангуй хялбар хэмжигдэхүүнийг сонгох;
3. Үндэслэл бүхий – Үнэлгээний шалгуурын талаар чухал мэдээллийг өгч болохуйц хэмжигдэхүүн байх; болон
4. Уялдаа холбоо бүхий – Хэмжигдэхүүн болон үнэлгээний шалгуур хоорондын харилцан хамаарлыг шууд ойлгож мэдэхэд хялбар байх.

Илүү ойлгомжтой болгох үүднээс дээр II-р хэсэгт заасан үйл ажиллагааны зарчмын дагуу процесс ба үр дагаварт үнэлгээ өгөх хүсэлтэй хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэгчид загвар үнэлгээний төлөвлөгөөг 4-р дүрсэд танилцуулж байна. Тухайлбал, нэг улсын хууль зүйн мэргэжлийн туслалцаа

үзүүлэгч байгууллага дээр зарчмуудаас өөрт чухал гэсэн үйл ажиллагаануудыг сонгоод, ийнхүү эл сонгосон үйл ажиллагааны зарчмын хүрээнд тус улс эсхүл түүний байгууллага үйлчлүүлэгчийг эрх чөлөө, сэтгэл ханамжийг хангахад чиглэсэн “зорилтот үйлчилгээ”-г (үнэлгээний процессын хэсэг) дээд зэргээр үзүүлж, “зорилто үр дүн”-д (үнэлгээний үр дагаврын хэсэг) хүрч чадаж байна уу эсхүл үгүй юу гэдгээ үнэлмээр байна гэж бодъё. Үнэлгээ хийхийн тулд бүх үзүүлэлтийг бус, харин цуглуулж үнэлэхэд хялбар үндэслэлтэй ба уялдаа холбоо бүхий цөөн хэдэн тооны үр дүн ба үр дагаврыг сонгоход хангалттай.

4-р дүрсэд буй үнэлгээний төлөвлөгөөнд үйл ажиллагаа буюу авах арга хэмжээ, үр дүн, мэдрэгдсэн үр дагавар болон хэргийн үр дагаврын хоорондын харилцан хамаарал, уялдаа холбоог ойлгомжтой хэлбэрээр танилцуулсан. Тус төлөвлөгөөг боловсруулахдаа яагаад тодорхой үйл ажиллагааг сонгосон, түүгээр ямар үр дагавар бий болохыг тооцоолж болох вэ гэдгийг нарийвчлан тайлбарласнаас гадна цаашид ямарваа нэгэн өөрчлөлт оруулж, засан сайжруулахад нээлттэй байх тал дээр анхаарсан болно. Олон улсын хэмжээнд хууль

зүйн мэргэжлийн туслалцааны сайн жишиг гэдэгт юуг ойлгох, гүйцэтгэлийн стандарт ямар байх ёстой талаар ерөнхий ойлголт нэгэнтээ тогтсон учраас үйл ажиллагааны чанарыг тодорхойлоход хялбар дөхөм байхын зэрэгцээ олон улсын шилдэг практик жишээнүүдээс үйлчлүүлэгчийн амьдралд бодит өөрчлөлт гарснаас суралцаж, хууль зүйн туслалцааны тогтолцоог боловсронгуй болгох боломж бүрдэнэ.

4-р дүрс

Процесс ба үр дагаврыг үнэлэх төлөвлөгөө

<p>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРЧМУУД</p> <p>Эрүүгийн хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэгчид өөрийн үйл ажиллагаа, гүйцэтгэлийн стандартад дараах зарчмыг баримталж ажиллана.</p>	<p>ГОЛ АЖИЛЛАГАА</p> <p>Үйл ажиллагааны зарчимд нийцүүлж боловсруулсан Гүйцэтгэлийн стандартад эрүүгийн хууль зүйн мэргэжлийн туслалцаа хуульчийг дараах арга хэмжээг хэргийн үе шатаас хамаарч хэрэгжүүлэхийг заасан байна.</p>	<p>ГОЛ ҮР ДҮН</p> <p>Хуульчид эдгээр үйл ажиллагааг хэрэгжүүлснээр үпроцессын үнэлгээний шатанд мэргэжлийн туслалцааны үйлчилгээнд дараах үр дүн гарсан байна.</p>	<p>ГОЛ МЭДРЭГДСЭН ҮР ДАГАВАР</p> <p>Эцэст нь бүх арга хэмжээг зохих ёсоор авсны дараа богино хугацаанд үйл ажиллагааны дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд: өмгөөллийн үйлчилгээ, шүүхийн системийн талаарх үйлчлүүлэгчийн сэтгэгдэл, байр суурь, өөрийн эрхийг ухамсарлаж хамгаалах байдал г.м.</p>	<p>ХЭРГИЙН ГОЛ ҮР ДАГАВАР</p> <p>Эцэст нь бүх арга хэмжээг зохих ёсоор авсны дараа үйл ажиллагаа дараах байдлаар өөрчлөгдсөн байна.</p>
<p>1. Эрт төлөөлөх - үйлчлүүлэгчийг баривчлагдах эсхүл баривчлагдсан, цагдан хоригдсон даруйд, аливаа байцаалтыг авахаас өмнө цаг алдалгүй уулзах, өмгөөлөгчөөр томилогдсоноос хойш 24 цагийн дотор үйлчлүүлэгчтэй уулзаж ярилцах.</p> <p>2. Үйлчлүүлэгч төвтэй өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх - үйлчлүүлэгчид бүрэн гүйцэд мэдээлэл зөвлөгөөг өгч, хэрэгт холбоотой чухал шийдвэрийг гаргахад туслалцаа үзүүлэх.</p> <p>3. Шүүхийн өмнөх шатанд эрх чөлөөтэй байх эрхийг хангах - шүүхийн өмнөх шатанд баривчлагдах, цагдан хоригдохоос сэргийлж, таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан бол суллах арга хэмжээг аль болох цаг алдалгүйгээр авч ажиллах.</p>	<ul style="list-style-type: none"> • Хэрэгт томилогдсоноос хойш 24 цагийн дотор үйлчлүүлэгчтэй анхны уулзалтыг хийх • Томилогдсоноос хойш 72 цагийн дотор үйлчлүүлэгчтэй дэлгэрэнгүй ярилцаж зөвлөгөө өгөх уулзалтыг хийх • Шүүхийн өмнөх шатанд үйлчлүүлэгчийг суллах асуудлыг хэлэлцүүлэхээр шүүхэд хүсэлт гаргах • Шүүх хуралдаан тус бүрд үйлчлүүлэгчийг бэлтгэж, түүнтэй уулзах • Үйлчлүүлэгчид яллах талын байр суурийг цаг тухайд нь танилцуулах 	<ul style="list-style-type: none"> • Хуульч хэрэгт томилогдсоноос хойш 24 цагийн дотор үйлчлүүлэгчтэй анхны уулзалтыг хийсэн хувь хэмжээ • Томилогдсоноос хойш 72 цагийн дотор үйлчлүүлэгчтэй дэлгэрэнгүй ярилцаж зөвлөгөө өгөх уулзалтыг хийсэн хувь хэмжээ • Үйлчлүүлэгчийг шүүхийн өмнөх шатанд цагдан хоригдсон хэрэгт өмгөөлөгчийн гаргасан хүсэлт, гомдлын хувь хэмжээ • Үйлчлүүлэгчтэй хийгдсэн харилцааны тоо(уулзалт, утасны 	<ul style="list-style-type: none"> • Шүүх хуралдаан дахь өмгөөлөгчийн төлөөллийн үйл ажиллагаатай холбоотой үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж нэмэгдсэн эсэх, сэтгэл хангалуун үйлчлүүлэгчдийн тоо нэмэгдсэн эсэх, хувь хэмжээгээр • Өмгөөлөгч үйлчлүүлэгчтэй хийсэн уулзалтын тоо, давтамж, хугацаа ба үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж нэмэгдсэн эсэх, хувь хэмжээгээр • Өмгөөлөгчийн зөвлөгөөтэй холбоотой үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж, ба сэтгэл хангалуун үйлчлүүлэгчдийн тоо нэмэгдсэн эсэх, хувь хэмжээгээр 	<ul style="list-style-type: none"> • Шүүх хуралдаан хүртэл эрх чөлөөтэй буй үйлчлүүлэгчдийн тоо нэмэгдсэн эсэх, хувь хэмжээгээр • Санхүүгийн байдалд нийцсэн, төлөх боломжтой хэмжээний батлан даалт гаргасан үйлчлүүлэгчдийн тоо нэмэгдсэн эсэх, хувь хэмжээгээр • Тэнссэн хугацаанд зөрчил гаргаагүй үйлчлүүлэгчдийн тоо нэмэгдэн эсэх, хувь хэмжээгээр

		дуудлага, харилцаа)	бичгэн	<ul style="list-style-type: none"> • Өмгөөлөгчид итгэдэг үйлчлүүлэгчийн тоо нэмэгдсэн эсэх, хувь хэмжээгээр • Үйлчлүүлэгч өөрийн хэрэгтэй холбоотой чухал шийдвэрийг гаргасан гэж үзэж байгаа эсэх, ийм үйлчлүүлэгчдийн тоо нэмэгдсэн эсэх 	
4. Хараат бус байдлаар үйл баримтыг судлан шинжих нөхцлийг бүрдүүлэхэд оролцох - бие даасан хэлбэрээр үйл баримтыг судлан шинжлэх арга хэмжээг авах. Үүнд: хэргийн газар очиж танилцах, боломжит бүх гэрчүүдтэй уулзаж ярилцах г.м.	<ul style="list-style-type: none"> • Хэргийн бүх үйл баримтыг бие даан судлан шинжлэх • Бүх боломжит гэрчүүдтэй уулзаж ярилцах арга хэмжээг авах • хэрэг болсон болон баривчлагдсан газар очиж танилцах 	<ul style="list-style-type: none"> • Үйл баримтыг судлан шинжлэхэд гаргасан бичгэн төлөвлөгөөний тоо • Шүүх хуралдаанаас гадуурх гэрчтэй уулзсан тохиолдлын хувь хэмжээ • Гэмт хэргийн газар очиж, үйл баримттай танилцсан тохиолдлын хувь хэмжээ 	Өмгөөлөгч эрхийг нь хамгаалахаар гаргаж буй хичээл зүтгэлд сэтгэл хангалуун үйлчлүүлэгчдийн тоо, хувь хэмжээ нэмэгдсэн эсэх	<ul style="list-style-type: none"> • Шүүхийн өмнөх шатанд хэргэсэхгүй болсон хэргийн тоо нэмэгдсэн эсэх, хувь хэмжээгээр • Цагаатгагдсан эсхүл илүү хөнгөн ял авсан хэргийн тоо нэмэгдсэн эсэх, хувь хэмжээгээр • Анх яллагдсан дүгнэлтээс үйлчлүүлэгчид илүү давуу байдлаар шийдвэрлэгдсэн хэргийн тоо нэмэгдсэн эсэх, хувь хэмжээгээр 	
5. Бэлтгэл ажлыг сайтар хангах - уялдаа холбоо, үр бүтээл бүхий, иж бүрэн цогц хэргийн төлөвлөгөө, стратегийг боловсруулж, шүүх хуралдаан тус бүр оролцох бэлтгэл ажлыг сайтар хангах 6. Шинжээчийн оролцоог хангах - мэргэжлийн шинжээчдээс зөвлөгөө авах, тэднийг хамруулах, мөн гэрчүүдийг оролцуулах.. 7. Шүүхийн өмнөх шатны ажиллагаанд оролцох - шүүхийн өмнөх шатны бүх ажиллагаанд үйлчлүүлэгчид ашигтай байж	<ul style="list-style-type: none"> • Цаг тухайд нь хэргийн материалтай танилцаж, шаардлагатай хүсэлт, гомдол боловсруулж, бэлтгэлтэй байх • Шүүх хуралдаан бүрд өмгөөлөх хамгийн сайн арга, тактикийг боловсруулж, тэмдэглэл хөтлөх • Боломжтой бол шинжээч болон бусад Мэргэжилтнүүдтэй уулзаж зөвлөгөө авах 	<ul style="list-style-type: none"> • Шүүх хуралдааны нээлт, хаалтын үг, гэрчээс асуух асуултууд зэрэг үйлчлүүлэгчийг өмгөөлөхөд боловсруулсан баримт бичгийн тоо, хувь хэмжээгээр • өмгөөлөгч шинжээчийг оролцуулсан тохиолдлын тоо • Өмгөөлөгчийн гаргасан бичгэн хүсэлт, гомдлын тоо 	<ul style="list-style-type: none"> • Өмгөөлөгчийн бэлтгэл ажилд сэтгэл хангалуун үйлчлүүлэгчдийн тоо нэмэгдсэн эсэх, хувь хэмжээгээр • Шүүх хуралдаан дахь өмгөөлөгчийн гүйцэтгэлд сэтгэл хангалуун үйлчлүүлэгчдийн тоо нэмэгдсэн эсэх, хувь хэмжээгээр • Хэргийн үр дүнд сэтгэл хангалуун үйлчлүүлэгчдийн 	<ul style="list-style-type: none"> • Үгүйсгэгдсэн эсхүл хавтаст хэргээс хасагдсан нотлох баримтын тоо нэмэгдсэн эсэх, хувь хэмжээгээр • Шүүхийн өмнөх шатанд хэргэсэхгүй болсон хэргийн тоо нэмэгдсэн эсэх, хувь хэмжээгээр • Цагаатгагдсан эсхүл илүү хөнгөн ял авсан хэргийн тоо нэмэгдсэн эсэх, хувь хэмжээгээр 	

<p>болохуйц бүхий л гомдол, хүсэлтийг цаг тухайд нь гаргах, материаллаг болон процессийн эрх зүйн хэм хэмжээг ур чадвар, туршлагадаа тулгуурлан зөв ба оновчтой хэрэглэх.</p> <p>8. Шүүхийн шатанд үйлчлүүлэгчийг хамгаалах - тодорхой, оновчтой, хүчтэй үндэслэлүүдийг гаргаж, хууль болон үйл баримтуудыг зөв хэрэглэх, гэрчүүдэд зүй зохистой, оновчтой асуултыг тавих.</p>	<ul style="list-style-type: none"> • Хохирол барагдуулах нөхцөл бий бол шаардлагатай хүсэлт, гомдлыг боловсруулж хүргүүлэх • Хэргийг хэрэгсэхгүй болгох үндэслэл бий гэж үзвэл шаардлагатай бүх арга хэмжээг авч, үйлчлүүлэгчийн хохирлыг сэргээх • Гэрчүүдийг нүүрэлдүүлж мэдүүлэг авах замаар үйлчлүүлэгчийн байр суурийг хамгаалж өмгөөлөх 		<p>тоо нэмэгдсэн эсэх, хувь хэмжээгээр</p> <ul style="list-style-type: none"> • Өөрийн өмгөөлөгчийг чадвартай хуулийн мэргэжилтэн гэж бодож буй үйлчлүүлэгчдийн тоо нэмэгдсэн эсэх, хувь хэмжээгээр 	<ul style="list-style-type: none"> • Анх ялагдсан дүгнэлтээс үйлчлүүлэгчид илүү давуу байдлаар шийдвэрлэгдсэн хэргийн тоо нэмэгдсэн эсэх, хувь хэмжээгээр
<p>9. Ял оногдуулах бүхий л нөхцөл байдалд оролцох - эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх, хөнгөрүүлэх, хамгийн бага эрүүгийн хариуцлагыг оногдуулах нөхцөлийг судлах, үйлчлүүлэгчийг хамгаалах, боломжтой бол эрүүгийн хариуцлага дундаас сонгох боломжийг шүүгчид бий болгож хамгийн бага ялыг оногдуулах боломжийг танилцуулах.</p>	<ul style="list-style-type: none"> • Эрүүгийн хариуцлагыг сонгох боломжтой бол үйлчлүүлэгчид ашигтай ялыг танилцуулж, өөрийн байр сууриа хамгаалах • Эрүүгийн хариуцлагатай холбоотой аливаа нөхцөлд цаг алдалгүй идэвхтэй оролцох 	<ul style="list-style-type: none"> • Ялыг сонгох боломж, боловсруулсан төлөвлөгөөний тоо • Ял оногдуулахад өмгөөлөгч гэрчийг дуудаж оролцуулсан тохиолдлын тоо, хувь хэмжээгээр 	<ul style="list-style-type: none"> • Хэргийн үр дүнд сэтгэл хангалуун үйлчлүүлэгчдийн тоо нэмэгдсэн эсэх, хувь хэмжээгээр 	<ul style="list-style-type: none"> • Хорих ялаас бусад төрлийн ял авсан үйлчлүүлэгчдийн тоо нэмэгдсэн эсэх, хувь хэмжээгээр • Үйлчлүүлэгчид ногдуулсан ялын хэмжээний хугацаа буурсан эсэх, ялын дээд хэмжээтэй харьцуулж хувийг гаргах
<p>10. Хэргийг давж заалдах - цаг алдахгүйгээр давж заалдах, хяналтын шатанд гомдол гаргах, үйлчлүүлэгчийн эрх, ашиг сонирхлыг зөрчсөн байж болзошгүй бүхий л асуудлыг хууль тогтоомжийн хүрээнд хөндөж танилцуулах.</p>	<ul style="list-style-type: none"> • Цаг тухайд нь гомдол гаргах, бүртгэл хөтлөх 	<ul style="list-style-type: none"> • Давж заалдах шатны шүүх хэргийг хүлээж аваагүйтэй холбоотойгоор гаргасан гомдлын тоо, хувь хэмжээ • Давж заалдах эсхүл хяналтын шатанд гаргасан гомдлын тоо, хувь хэмжээ 	<ul style="list-style-type: none"> • Хэргийн үр дүнд сэтгэл хангалуун үйлчлүүлэгчдийн тоо нэмэгдсэн эсэх, хувь хэмжээгээр • Өмгөөлөгч эрхийг нь хамгаалахаар хүчин зүтгэл гаргаж байна гэж бодож буй үйлчлүүлэгчдийн тоо 	<ul style="list-style-type: none"> • Давж заалдах, хяналтын шатны шүүх дээр өөрчлөгдсөн ялын тоо нэмэгдсэн эсэх, хувь хэмжээгээр • Давж заалдах, хяналтын шатны шүүх дээр ялын төрөл, хэмжээ буурсан эсэх, эсхүл хэргийг

			<p>нэмэгдсэн эсэх, хувь хэмжээгээр</p> <ul style="list-style-type: none"> • Өөрийн өмгөөлөгчийг чадвартай хуулийн мэргэжилтэн гэж бодож буй үйлчлүүлэгчдийн тоо нэмэгдсэн эсэх, хувь хэмжээгээр 	<p>хэрэгсэхгүй болгосон эсэх, хувь хэмжээгээр</p>
--	--	--	--	---